

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 7564 дүгээрт бүртгэв.*

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 3 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар А/67

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Хамтын баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, түүнийг байгуулах, бүртгүүлэх, баталгаажуулалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Батшагай)-т, тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актыг бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс (Ч.Раднаабазар)-т тус тус даалгасугай.

3.Энэ журам батлагдсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Журам, аргачлал батлах тухай” А/09 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт, 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/590 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болгосугай.

САЙД

М.БАДАМСҮРЭН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2026 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А/67 дугаар тушаалын хавсралт

ХАМТЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТҮҮНИЙГ БАЙГУУЛАХ, БҮРТГҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Органик хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүнийг харилцан итгэлцэлд тулгуурлан, хамтран баталгаажуулах байгууллага /Цаашид “Хамтын баталгаажуулалтын байгууллага” гэх/-ыг Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд заасан хэлбэрээр байгуулна.

1.2.Хамтын баталгаажуулалтын байгууллага нь гишүүн үйлдвэрлэгчийнх нь бүтээгдэхүүн, үйл ажиллагаа Органик бүтээгдэхүүний тухай хууль тогтоомж болон бусад холбогдох дүрэм, журам, стандартад заасан шаардлагад нийцсэн эсэхийг харилцан бие биедээ хяналт тавих зарчмаар баталгаажуулан, баталгаажсан бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд санал болгох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.3.Энэ журмын 1.1-д заасан нөхөрлөлийн дундын хөрөнгө, эд хөрөнгийн хариуцлагыг Иргэний хуулийн 482 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

1.4.Хамтын баталгаажуулалтын байгууллага /Цаашид “ХББ” гэх/-ын гишүүнээр анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч, боловсруулах үйлдвэр, хэрэглэгч байх ба дундын борлуулагч, сүлжээ дэлгүүр, органик хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, нийгэмлэг, итгэмжлэгдсэн лаборатори нь ХББ-д гишүүнчлэлтэй байж болно.

Хоёр.Хамтын баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага

2.1.ХББ нь хамгийн багадаа 7 гишүүнтэй байх, гишүүдийн 60 ба түүнээс дээш хувь нь бүтээгдэхүүн болон үйл явцын баталгаажуулалтын чиглэлээр аудиторын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

2.2.ХББ-ын гишүүн Органик бүтээгдэхүүний тухай, Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, тогтоомж, стандартыг мөрдөн, аливаа зөрчил гаргахгүй ажиллах, энэ журмын 2.4.5, 4.2 ба 4.7 дахь хэсэгт заасан хяналт, шалгалтад хамрагдахад татгалзах зүйлгүй гэдгээ баталгаажуулж, олон нийтэд нээлттэй хэлбэрээр тангараг өргөж, тангаргийн бичгийг үйлдэнэ.

2.3.ХББ-ын гишүүд Органик бүтээгдэхүүний тухай хууль, журмыг үндэслэн, өөрийн үйл ажиллагааны болон газар зүйн онцлогт тохирсон соёл, зан заншил, уламжлалд нийцүүлэн хамтран ажиллах гэрээг байгуулна.

2.4.Энэ журмын 2.3-д заасан гэрээнд дараах зохицуулалтыг тусгана:

2.4.1.удирдлагын хэвтээ тогтолцоог бүрдүүлэх, сонгуульт гишүүдийг сэлгэх, гишүүдийн оролцоог хангах;

2.4.2.органик үйлдвэрлэлд шилжих шилжилтийн үеийг эхлүүлэх, бүтээгдэхүүн, үйл ажиллагааг баталгаажуулах, органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээг хэрэглэх, олгосон баталгааг сунгах, хүчингүй болгох шийдвэр гаргах, тайлагнах;

2.4.3.тангаргийн бичгийн загвар, тангараг өргөх;

2.4.4.хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүрэг болон тангаргийг зөрчихөд хүлээлгэх хариуцлагыг тооцох;

2.4.5.ижил төрлийн органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгч ХББ-ын гишүүд харилцан бие биеийнхээ, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч гишүүн нь анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч гишүүний үйл ажиллагааг тус тус хянаж, үнэлгээ өгөх, зөрчил, дутагдлыг илрүүлэх, гарсан зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

2.4.6.хяналт шалгалт хийх болон баталгаажуулалттай холбогдох зардлыг хуваарилах;

2.4.7.хяналт, шалгалтыг гүйцэтгэх явцад гарч болзошгүй сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.4.8.хяналт шалгалтад хамрагдсан гишүүний үйл ажиллагааны нууцтай холбоотой мэдээлэл болон тоо баримтыг эрх бүхий байгууллага болон албан тушаалтнаас бусад этгээдэд задруулахгүй байх;

2.4.9.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх тэгш байдлыг хангах;

2.4.10.ХББ-ын бүтэц, зохион байгуулалт, хяналт шалгалт, баталгаажуулалтын үйл ажиллагаа, органик үйлдвэрлэлийн талаар олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх.

2.5.ХББ нь хамтран ажиллах гэрээ байгуулсан тухай мэдээллийг Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу ажлын 10 өдөрт багтаан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр болон цахимаар хүргүүлнэ.

2.6.ХББ-ын өдөр тутмын үйл ажиллагааг ХББ-ын бүх гишүүдийн хурлаас сонгогдсон эрх бүхий төлөөлөгч хэрэгжүүлнэ.

2.7.ХББ нь оноосон нэр, тэмдэг, лого, хэвлэмэл хуудастай байна. Оноосон нэрийн ард “ХББ” гэсэн ялгах тэмдгийг хэрэглэнэ.

2.8.ХББ нь дотоод хяналтын тогтолцоотой байж шалгалт хийх шалгуур үзүүлэлтийн үнэлгээний үйл ажиллагаа стандарт, журмын

дагуу явагдаж буй эсэхийг хянах, Баталгаажуулалтын тогтолцооны найдвартай байдал, ил тод байдлыг хангах, илэрсэн зөрчил, алдаа дутагдалд үл тохирлын хариу арга хэмжээ авч, сайжруулалт хийх, гишүүдийн итгэлцэл, оролцоог дэмжин ажиллана. Дотоод хяналтыг гүйцэтгэхдээ дараах үйл явцыг хэрэгжүүлнэ.

2.8.1.дотоод хяналтын хамрах хүрээ, шалгах шалгуур, давтамж, хугацааг тодорхойлсон хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах;

2.8.2.баримт бичгийн хяналт, үнэлгээний тайлан, бүртгэлийн хяналттай (Маягт 2) байх;

2.8.3.гишүүдийн органик үйлдвэрлэл, үйл ажиллагаанд хяналт хийх;

2.8.4.оролцогчдын санал гомдлыг шалгаж шийдвэрлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.8.5.дотоод хяналтын тайлан гаргаж, сайжруулалтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.

Гурав.Хамтын баталгаажуулалтын байгууллагын бүртгэл

3.1.ХББ-ыг Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэнэ.

3.2.ХББ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг ирүүлнэ:

3.2.1.ХББ-аар бүртгүүлэх хүсэлт;

3.2.2.ХББ-ын талаарх ерөнхий мэдээлэл (Маягт 1-ийн дагуу);

3.2.3.энэ журмын 2.2-т заасан тангаргийн бичгийн хуулбар, 2.3-т заасан хамтран ажиллах гэрээ;

3.2.4.орон нутгийн хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн байгууллагын тодорхойлолт.

3.3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 3.2-т заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг хангасан эсэхийг нягталж, дутуу бичиг баримтыг шаардах ба бүрдүүлбэр хангагдсан тохиолдолд хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногт багтаан ХББ-г бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах шийдвэрийг гаргаж, татгалзсан тохиолдолд үндэслэлийг тайлбарлана.

3.4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бүртгэгдсэн ХББ-ын үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд Захиргааны гэрээ байгуулж, хяналт тавина.

3.5. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэгдсэн ХББ-ын талаарх мэдээллийг органик бүтээгдэхүүний мэдээллийн санд байршуулж, нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Хамтын баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаа

4.1. ХББ нь Органик бүтээгдэхүүний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж, стандартын шаардлагад үйлдвэрлэгчийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нийцэж буй эсэхэд баталгаа олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхтэй.

4.2. ХББ нь өөрийн гишүүдээс бүрдсэн баг томилон, хяналт шалгалт явуулж, тухайн багийн гаргасан дүгнэлтийг үндэслэн органик бүтээгдэхүүнд баталгаа олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

4.3. ХББ нь энэ журмын 4.2-т заасан багт орж ажиллах гишүүнийг Органик бүтээгдэхүүний тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, бусад хууль тогтоомж, стандартыг судлах, эдгээрт нийцүүлэн хяналт шалгалтын удирдамж аргачлал, хяналтын хуудсыг боловсруулах, үнэлгээ өгөх, хяналт шалгалтыг гүйцэтгэх, тайлагнах чиглэлийн сургалтад хамруулна.

4.4. Энэ журмын 4.2-т заасан багийн бүрэлдэхүүн, багийн гишүүн бүрийн эрх үүрэг, хариуцлага, шалгалтын төрөл, давтамж, хамрах хүрээг багтаасан удирдамж, шалгалтад ашиглах хяналтын хуудас, тайлангийн загварыг ХББ-ын хурлаас батална.

4.5. Органик үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагааг газар дээр нь очиж үнэлэх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хяналт шалгалт явуулах, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, органик бүтээгдэхүүнд баталгаа олгох, цуцлах шийдвэр гаргах үйл явцад ХББ-ын гишүүдийн оролцоог хангасан байна.

4.6. Энэ журмын 4.2-т заасан багийн бүрэлдэхүүнд судлаач, эрдэмтэд, тухайн орон нутгийн байгаль орчны чиглэлээр ажилладаг байгууллага, сургалтын байгууллага, нийгмийн эрүүл мэндийн байгууллага, төрийн байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

4.7. ХББ нь гишүүний үйл ажиллагаанд жилд нэг удаа төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг явуулна.

4.8. ХББ нь гишүүдийнхээ үйл ажиллагааны ноцтой зөрчлийн талаар иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн мэдээллийг хүлээн авч, тухайн үйлдвэрлэгчид мэдэгдэн, бодитой үнэлж, хяналт шалгалтыг төлөвлөн, үл тохирол, зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

4.9.Хяналт шалгалт явуулах, бүтээгдэхүүнд баталгаа олгох ажиллагааг хүнд суртал багатай, оновчтой хэлбэрээр явуулж, бүртгэл, тайлан мэдээ гаргах үйл явцыг хялбарчилж, орчин үеийн мэдээллийн дэвшилтэт технологийг (фото зураг, видео болон аудио бичлэг) ашиглаж болно.

4.10.ХББ нь энэ журмын 4.1-д заасан баталгааг олгохдоо мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, шаардлагатай тохиолдолд итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнг үндэслэж болно.

4.11.Энэ журмын 4.2-т заасан баг нь үнэлгээ өгөх явцыг хяналтын хуудас болон хяналт шалгалтын тайлангаар баримтжуулж, тухайн үйлдвэрлэгчид мэдээлэн, баталгаа олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох дүгнэлтийг гишүүдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

4.12.Баталгаа олгох шийдвэр нь шударга, ардчилсан зарчимд нийцсэн, ил тод нээлттэй байна.

4.13.ХББ нь Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь хэсэгт заасны дагуу баталгаажсан бүтээгдэхүүнийг бүртгүүлж, шошгод органик болохыг илэрхийлсэн тэмдэглэгээ тавих эрх олгох саналыг Хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.14.ХББ нь энэ журмын 4.13-т заасны дагуу баталгаажсан бүтээгдэхүүнд Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 11.6 болон 12.2-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тушаалыг мөрдөж ажиллана.

4.15.ХББ нь энэ журмын 2.3-д заасан гэрээ, түүний хэрэгжилт, органик үйлдвэрлэл эрхлэгч, баталгаажсан органик бүтээгдэхүүний төрөл, үйлдвэрлэлийн тоо хэмжээ, борлуулалт, зах зээлийн үнийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь хэсэгт заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутамд хүргүүлж, органик бүтээгдэхүүний хяналт, удирдлагын мэдээллийн систем, өөрийн байгууллагын албан ёсны цахим хуудас болон бусад мэдээллийн сувгаар дамжуулан олон нийт, хэрэглэгчдэд тогтмол мэдээлнэ.

Тав.ХББ-ын үйл ажиллагааны ил тод байдал

5.1.ХББ нь өөрийн үйл ажиллагаагаа нээлттэй, тогтвортой, шударга явж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор удирдлага, зохион байгуулалтын дараах үйл ажиллагааг баримтжуулна:

5.1.1.ХББ-ын талаарх ерөнхий мэдээлэл (Маягт 1-ийн дагуу);

5.1.2.тангараг (гарын үсэг зурсан бичмэл хувь, эсхүл аудио, видео бичлэг);

5.1.3.энэ журмын 2.3-т заасан гэрээ, түүний хэрэгжилтийн тайлан;

5.1.4.хяналт шалгалтын тайлан, хяналтын хуудас, үл тохирол, зөрчлийн тухай мэдээлэл, зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тухай тайлан;

5.1.5.гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, ирцийн бүртгэл;

5.1.6.баталгаа олгосон гэрчилгээний хуулбар хувь.

5.2.Энэ журмын 5.1-т заасан бүртгэлийн бичиг баримт нь олон нийтэд нээлттэй байна.

5.3.ХББ нь хяналт, үнэлгээндээ үйлдвэрлэл эрхлэгч гишүүн бүрийн онцлогт тохируулан, хүнсний сүлжээний холбогдох үе шатанд ул мөр мөрдөн тогтоох бүртгэл, эрүүл ахуй болон дотоод хяналтын бүртгэлийг багтааж, органик хяналтын шалгуур үзүүлэлттэй уялдуулна.

5.4.ХББ-ын баталгаажуулалтын төлбөр, зарцуулалтын талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

5.5.ХББ нь үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй байлгах, сурталчлан таниулах зорилгоор нийт хэрэглэгч, иргэд, гишүүн бус хөндлөнгийн байгууллага, ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг хамруулан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг жилд 1-ээс дээш удаа зохион байгуулна.

5.6.ХББ нь гишүүд хоорондоо харилцан туршлага, мэдлэгээ хуваалцах, дамжуулах, түгээх, дадлагажих, газар дээр нь очиж зөвлөгөө өгөх чиглэлээр сургалт хэлэлцүүлгийг төлөвлөж, хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах гэрээнд тусгаж ажиллана.

Зургаа.Хамтын баталгаажуулалтын байгууллагад тавих хяналт

6.1.Хамтын баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцогч талуудын дотоод болон хамтын хяналтаас гадна төрийн бодлого, зохицуулалтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хяналт, үнэлгээ хийх, мэдээллийн ил тод байдалд хяналт тавих эрхтэй байна.

6.2.ХББ-ын үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас дараах чиглэлээр хяналт тавина:

6.2.1.Төрийн хяналтыг хэрэгжүүлэх, баталгаажуулалт, дотоод хяналтын тогтолцоонд хяналт-шинжилгээ хийх;

6.2.2.Ил тод байдал, хариуцлагын тогтолцоог үнэлэх;

6.2.3.Органик бүртгэл мэдээллийн санг ашиглан шалгах;

6.2.4.Шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэлд үндэслэн газар дээрх шалгалт хийх.

6.3.Хяналт шалгалтын үр дүнгээс шалтгаалан дараах шат дараалсан арга хэмжээг авах эрхтэй:

- 6.3.1.Зөвлөмж, сайжруулалтын заавар өгөх;
- 6.3.2.Дахин үнэлгээ хийх, гүйцэтгэлийг шалгах;
- 6.3.3.Албан шаардлага хүргүүлэх;
- 6.3.4.Бүртгэлийг түр түдгэлзүүлэх/хүчингүй болгох;

6.3.5.Ил тод байдлын зарчимд үндэслэн олон нийтэд холбогдох мэдэгдэл хүргүүлэх, мэдээллийн санд мэдэгдэл байршуулах.

6.4.ХББ-аар бүртгэгдсэнээс хойш сүүлийн 3 жил тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй бол Органик бүртгэл мэдээллийн системээс хасна.

6.5.ХББ-ын тогтолцоог дэмжих бодлого хэрэгжүүлэх, мэргэжлийн зөвлөгөө, сургалт, техникийн дэмжлэг үзүүлж болно.

Маягт 1

ХББ-ЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.ХББ-ын оноосон нэр:
- 2.ХББ-ын лого:
- 3.ХББ-ыг байгуулсан он, сар, өдөр:
- 4.Харьяа аймаг, хот, сум, дүүрэг:
- 5.Үйл ажиллагааны чиглэл:
- 6.Хяналтын байгууллагаас хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид олгосон бүртгэлийн дугаар:
- 7.ХББ-ын гишүүдийн тоо:
- 8.ХББ-ын гишүүдийн хамтран ажиллах гэрээний хуулбар;
- 9.Эрх бүхий төлөөлөгчийн товч анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, цахим шуудангийн хаяг, утас;
- 10.ХББ-ын гишүүдийн дундын хөрөнгө:
- 11.Үйл ажиллагаа тогтмол явуулах байр: Өөрийн/түрээсийн Хаяг:
- 12.Утас:
- 13.Факс:
- 14.Цахим хуудас:
- 15.Цахим шуудангийн хаяг:
- 16.Тоног төхөөрөмжийн хангамж: компьютер, утас, цахим сүлжээ, автотээврийн хэрэгсэл;
- 17.Органик хүнс, хөдөө аж ахуйн болон хүнсний бус чиглэлийн хяналт шалгалт явуулах, баталгаа олгох боловсон хүчний чадавх, туршлага / нотлох баримтыг хавсаргах/;
- 18.Гишүүдийн овог нэр /хэрвээ гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага бол нэр, хаяг, улсын бүртгэлийн дугаар, иргэн бол овог нэр, регистрийн дугаар, хаяг/
- 19.ХББ-ын гишүүдийн үйлдвэрлэлд ашиглаж буй газрын хэмжээ, га-аар, хаяг, кадастрын зураглал:
- 20.Тариалангийн талбайн хэмжээ: Бэлчээрийн хэмжээ:
- 21.Байгалийн ургамал, жимс түүх талбайн хэмжээ:
- 22.Бусад:

ДОТООД ХЯНАЛТЫН ТАЙЛАН

1. Тайлангийн ерөнхий мэдээлэл

№	Тайлан гаргасан ХББ-ын нэр	
1	Хяналт хийсэн баг/гишүүн	
2	Хяналт хийсэн хугацаа	
3	Тайлангийн огноо	
4	Хамрагдсан фермер /мал аж ахуй/ үйлдвэр тоо	
5	Хамрагдсан бүтээгдэхүүний нэр төрөл	

2. Хяналтын хүрээ ба аргачлал

Хянасан баримт бичиг (шалгах хуудас, үнэлгээний тайлан, гомдлын бүртгэл г.м):

Аргачлал: _____ Баримт бичгийн хяналт: _____ Түүвэр шалгалт: _____

Ярилцлага: _____ Гомдол, саналын үнэлгээ: _____

3. Илэрсэн эерэг талууд (Сайн туршлага, давуу тал)

№	Агуулга	Тайлбар

4. Илэрсэн зөрчил, алдаа, сайжруулах шаардлагатай асуудал

№	Зөрчил/доголдол	Хаана илэрсэн	Хамаарах стандарт/журам	Тайлбар

5. Залруулах, сайжруулах арга хэмжээ

№	Арга хэмжээ	Хариуцагч	Хугацаа	Гүйцэтгэл

6. Дүгнэлт, зөвлөмж

Дотоод хяналтын ерөнхий үнэлгээ (үйл ажиллагаа тогтвортой байгаа эсэх, сайжруулалт шаардлагатай эсэх, нэн даруй залруулах арга хэмжээ авах талаар дүгнэлт, зөвлөмжийг гаргах): _____

_____ Нэмэлт санал, дүгнэлт: _____

7.Тайлан гаргасан хүний гарын үсэг

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

Гарын үсэг: _____

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 1 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар А/3

Улаанбаатар
хот

ЖУРАМ, АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Дуудлага худалдааны зориулалттай үнэлгээний журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Дуудлага худалдааны зориулалттай үнэлгээний аргачлал”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т даалгасугай.

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

*Сангийн сайдын 2026 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн
А/3 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗОРИУЛАЛТТАЙ ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар дуудлага худалдааны зориулалтаар хөрөнгийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Дуудлага худалдааны зориулалтаар хөрөнгийн үнэлгээ хийхдээ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Иргэний хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Үнэлгээний олон улсын стандарт (цаашид “ҮОУС” гэх), бусад холбогдох хууль, журам, аргачлалыг баримтална.

1.3.Дуудлага худалдааны зориулалттай хөрөнгийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5.1.3-т заасан үндэслэлээр үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээд (цаашид “үнэлгээчин” гэх) хийнэ.

Хоёр.Хөрөнгийн үнэлгээнд тавигдах шаардлага

2.1.Үнэлгээчин нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1.үнэлгээчний эрх, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;

2.1.2.дуудлага худалдааны зориулалтаар хөрөнгийн үнэлгээ хийх үнэлгээчин нь хөрөнгийн мэргэшсэн, тэргүүлэх зэрэгтэй үнэлгээчин байх;

2.1.3.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хараат бус байдлыг хангасан байх.

2.2.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 23.1.4, 23.1.5-д заасан олон улсын хөрөнгийн үнэлгээний тайлагналын стандартын дагуу мэргэжлийн байгууллагаас боловсруулан гаргасан гэрээт ажлын захидал, үнэлгээний шалгах хуудас зэрэг үлгэрчилсэн загвар, заавар, хэрэглээний тайлбар, зөвлөмжийг ашиглан хөрөнгийг үнэлнэ.

2.3.Үнэлгээчин нь бэлтгэл ажлын хүрээнд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний мэдээллийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн систем болон улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэлтэй, оюуны өмчийн хүчинтэй хугацаа, төлөвийн мэдээллийг оюуны өмчийн мэдээллийн сан, оюуны өмчийн газраас эрхлэн гаргасан албан ёсны хэвлэлийн мэдээлэлтэй тус тус тулган баталгаажуулсан байна.

2.4.Үнэлгээчин нь үл хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн онцлог, тодорхой бус, нарийн төвөгтэй байдлыг харгалзан, барилгын төсөвчин, зөвлөх инженер, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч,

холбогдох салбарын мэргэжилтнийг татан оролцуулж болно.

2.5. Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээнд хэрэглэх үнэ цэнийн суурь, үнэ цэнийн урьдчилсан нөхцөл, үнэлгээний өдөр, зорилтот хэрэглэгч, үнэлгээ хийх хугацаа, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой гарах зардал, үнэлгээний үр дүнг хэрэглэх нөхцөл зэрэг ажлын цар хүрээг үйлчлүүлэгчид танилцуулан гэрээт ажлын захидлаар баталгаажуулна.

2.6. Үнэлгээчин нь дуудлага худалдааны зориулалтаар хөрөнгийн үнэлгээ хийхдээ тухайн хөрөнгө нь иж бүрдэл хөрөнгийн салшгүй хэсэг эсэх, хөрөнгийн бүрдлээс нь салгаж тусад нь худалдан борлуулах боломжтой эсэхийг нягталсан байна.

2.7. Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээний зүйлтэй газар дээр нь үзэж танилцан, үнэлгээний зүйлийн бүрэн бүтэн байдал, чанар байдал, цаашид зориулалтын дагуу ашиглах боломж, давуу болон дутагдалтай талыг бодитой тодорхойлсон байна.

2.8. Энэ журмын 2.7-д заасан ажлын үр дүнг баталгаажуулан шалгах хуудсыг бөглөж, захиалагч, хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, эсхүл хадгалалт, хамгаалалтыг хариуцаж байгаа этгээд болон үнэлгээчин гарын үсэг зурж баталгаажуулна.

Гурав. Дуудлага худалдааны зориулалтаар хөрөнгийн үнэлгээ хийлгэх этгээд

3.1. Дуудлага худалдааны зориулалтаар хөрөнгийн үнэлгээ хийлгэх этгээд (цаашид “эрх бүхий этгээд” гэх) нь хөрөнгийн үнэлгээ хийх шийдвэр, ажлын даалгаврыг боловсруулан батална.

3.2. Ажлын даалгаварт дараах зүйлийг тусгана. Үүнд:

3.2.1. үнэлгээ хийхэд баримтлах ашиглалтын нөхцөл (үнэ цэнийн урьдчилсан нөхцөл);

3.2.2. зах зээлийн, эсхүл тэгш шударга үнэ цэнийн алийг тодорхойлох;

3.2.3. үнэлгээний өдөр;

3.2.4. хөрөнгийн тодорхойлолт;

3.2.5. бусад.

3.3. Эрх бүхий этгээд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2.2, 69.2.3, 69.2.4, 69.2.5, 69.3-т заасан бичиг баримтыг хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардлагатай бусад бичиг баримтын хамт үнэлгээчинд хүргүүлнэ.

3.4. Эрх бүхий этгээд нь нээлттэй зах зээлд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах зорилгоор үнэлгээ хийлгэхэд зах зээлийн үнэ цэнийг тодорхойлохыг шийдвэр эсхүл ажлын даалгаварт тусгана. Хэрэв хаалттай зах зээлд хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулах тохиолдолд зах зээлийн үнэ цэнэ, эсхүл тэгш шударга

үнэ цэнийн алийг тодорхойлохыг шийдвэр эсхүл ажлын даалгаварт тусгана.

3.5.Эрх бүхий этгээд нь хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлох үнэлгээний өдрийг ажлын даалгаварт тодорхой зааж өгнө.

3.6.Эрх бүхий этгээд нь зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох ажлыг хийлгэсэн тохиолдолд хөрөнгийн давуу сул талын талаар бүрэн мэдээллийг нээлттэй зах зээлийн оролцогчдод хүргэн сурталчилгаа мэдээллийг хүргэсэн байна.

3.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаас бусад тохиолдолд эрх бүхий этгээд нь хөрөнгийн үнэлгээний тайланд тусгасан хөрөнгийн үнэ цэнэ, хөрөнгийг борлуулах боломжит хугацаа зэрэг мэдээллийг дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлохдоо хэрэглэнэ.

Дөрөв.Хөрөнгийн үнэлгээний тайлан

4.1.Үнэлгээний тайлан нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 8.2-т заасан шаардлага, ҮОУС-д нийцүүлэн бэлтгэнэ.

4.2.Хөрөнгийн үнэлгээний тайланд мэргэжлийн байгууллагын тайлангийн мэдээллийн санд бүртгүүлсэн цахим дугаарыг хэрэглэнэ.

4.3.Хөрөнгийн үнэлгээний тайланг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 5 өдрийн дотор Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 12.1.8-д заасан мэдээллийг хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санд оруулна.

4.4.Хууль, дүрэм журмыг баримтлан үнэлгээ хийх явцад ҮОУС-д зааснаас өөр шаардлага тавигдан гажилт үүссэн тохиолдолд үнэлгээний тайланд тодруулга хийн, баримтжуулна.

Тав.Үнэлгээний үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт

5.1.Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаандаа дотоод чанарын хяналтыг хэрэгжүүлнэ.

5.2.Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээ хийхэд ашигласан орц мэдээлэл болох үйлчлүүлэгчээс хүлээн авсан мэдээлэл, цуглуулсан судалгаа, нотолгоо баримт мэдээллийг үнэлгээний тайлангийн хамт архивын нэгж болгон хадгална.

5.3.Хөрөнгийн үнэлгээтэй холбоотой гомдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

5.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаас бусад тохиолдолд хөрөнгийн үнэлгээтэй холбоотой гомдлыг холбогдох хуулиар шийдвэрлүүлнэ.

*Сангийн сайдын 2026 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн
А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

**ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗОРИУЛАЛТТАЙ ҮНЭЛГЭЭНИЙ
АРГАЧЛАЛ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Дуудлага худалдааны зориулалтаар хөрөнгийн үнэлгээ хийхэд энэхүү аргачлалыг баримтална.

Хоёр.Дуудлага худалдааны төрөл

2.1.Дуудлага худалдааны зориулалттай хөрөнгийн үнэлгээ дараах төрөлтэй байна. Үүнд:

2.1.1.үнэ хаялцуулах дуудлага худалдаа;

2.1.2.албадан дуудлага худалдаа.

2.2.Үнэлгээчин нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 64.1-д заасныг үндэслэн дуудлага худалдааны төрлийг тодорхойлно.

Гурав.Хөрөнгийн үнэлгээ хийх ажлын үе шат

3.1.Үнэлгээчин нь үнэлгээ хийхдээ дараах үе шатыг баримтална. Үүнд:

3.1.1.үнэлгээний ажлын зорилго ба зориулалт, зориулагдсан хэрэглээнд нийцсэн үнэ цэнийн суурийг сонгож, үнэлгээний ажлын цар хүрээг тодорхойлох;

3.1.2.үнэлгээний багийн бүрэлдэхүүн, оролцоо, төлөвлөгөө, төсөв, ажлын хуваарийг боловсруулах;

3.1.3.үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж, гэрээт ажлын нөхцөлийг тохиролцож гэрээт ажлын захидлаар баталгаажуулах;

3.1.4.хөрөнгийн үнэлгээний зүйлтэй газар дээр нь үзэж танилцан, үнэлгээний зүйлийн бүрэн бүтэн байдал, чанар, цаашид зориулалтын дагуу ашиглах боломж, давуу болон дутагдалтай тал, тухайн хөрөнгийг тусад нь салгаж дуудлага худалдаагаар худалдах боломжтой эсэхийг тодорхойлох;

3.1.5.хөрөнгийн үнэ цэнийн тооцоолол хийх;

3.1.6.үнэлгээний үр дүнг нэгтгэн хөрөнгийн үнэлгээний тайлан, зөвлөмж бэлтгэж, үйлчлүүлэгчид хүргүүлэх.

3.2.Үнэлгээчин нь энэ аргачлалын 2.1.1-д заасан төрлөөр үнэлгээ хийх тохиолдолд “хамгийн өндөр ба хамгийн сайн”, “одоогийн ашиглалт” гэсэн үнэ цэнийн урьдчилсан нөхцөлийн аль тохиромжтойг хэрэглэнэ. Үүнд:

3.2.1.“Хамгийн өндөр ба хамгийн сайн” үнэ цэнийн урьдчилсан нөхцөлөөр тодорхойлсон зах зээлийн үнэ цэнэ нь хөрөнгийн ашиглалтын хэд хэдэн хувилбараар тооцоолсон хамгийн өндөр үнэ

цэнийг илэрхийлнэ;

3.2.2.“Одоогийн ашиглалт” үнэ цэнийн урьдчилсан нөхцөлөөр тодорхойлсон зах зээлийн үнэ цэнэ нь одоо хөрөнгийг ашиглаж байгаа нөхцөлд тохирсон үнэ цэнийг илэрхийлнэ.

3.3.Үнэлгээчин нь 2.1.2-т заасан төрлөөр үнэлгээ хийх тохиолдолд “албадан борлуулалт”, “эрэмбэ дараатай устгалт” гэсэн үнэ цэнийн урьдчилсан нөхцөлийн аль тохиромжтойг хэрэглэнэ. Үүнд:

3.3.1.“Албадан борлуулалт” үнэ цэнийн урьдчилсан нөхцөлөөр тодорхойлсон зах зээлийн үнэ цэнэ нь хөрөнгийг богино хугацаанд сурталчлан борлуулах үнэ цэнийг илэрхийлнэ;

3.3.2.“Эрэмбэ дараатай устгалт” үнэ цэнийн урьдчилсан нөхцөлөөр тодорхойлсон зах зээлийн үнэ цэнэ нь худалдан авагч нь төлбөрийг тодорхой хугацаанд хуваан төлөх нөхцөлд тохирсон үнэ цэнийг илэрхийлнэ.

3.4.Үнэлгээчин нь үнэлгээний зүйлийн бүрэн бүтэн байдал, чанартай байдалд дүгнэлт гаргахдаа тухайн салбарын мэргэжилтнийг татан оролцуулж болно.

3.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаас бусад тохиолдолд үнэлгээчин нь борлуулах боломжит хугацааг хөрөнгийн төрөл, онцлогийг харгалзан зах зээлийн борлуулалтын судалгаа, мэдээлэлд үндэслэн тодорхойлно.

3.6.Үнэлгээний үр дүнг нэгтгэж, тайлан бэлтгэн, үйлчлүүлэгчид хүргүүлнэ.

Дөрөв.Хөрөнгийн үнэлгээ хийх хандлага, аргууд

4.1.Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээ хийхдээ хөрөнгийн төрөл, онцлогийг харгалзан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан тохирох журам, аргачлалыг баримтлан үнэлгээ хийнэ.

4.2.Үнэлгээчин нь өөрийн болон бусад үнэлгээчний тодорхойлсон хөрөнгийн үнэ цэнийн мэдээллийг жиших орц мэдээлэлд ашиглахыг хориглоно.

Тав.Хөрөнгийн үнэлгээний тайлан

5.1.Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээ хийсэн аргын сонголт, үнэлгээний үр дүнг эцэслэхэд хэрэглэсэн жинлэлт, үнэлгээний тооцоололд хэрэглэсэн гол хүчин зүйлүүдийн тодорхойлолт, тайлбар, судалгаа шинжилгээний дүгнэлт, үнэлгээний тооцооллын үндэслэл зэрэг мэдээллийг үнэлгээний тайланд тодорхой тусган тайлбарласан байна.

5.2.Үнэлгээчин нь хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах боломжтой эсэх, борлуулах боломжит хугацааг үнэлгээний тайланд тусгаж болно.

5.3. Үнэлгээчин нь дуудлага худалдаанд оролцогч хөрөнгийг худалдан авах эсэх талаар шийдвэр гаргахад шаардлагатай хөрөнгийн давуу болон сул талыг тусгасан бодитой мэдээллийг тайлагнасан байна.

5.4. Үнэлгээний тайланд үнэлгээний үр дүнг хэрэглэх ба хязгаарлах нөхцөл, гажилт, хэрэглэсэн төсөөлөл нь нотлогдохуйц, үндэслэлтэй байна.

5.5. Үнэлгээчин нь дуудлагаар худалдах хөрөнгийг газар дээр нь очиж биечлэн үзлэг, хэмжилт хийсэн тэмдэглэл, шалгах хуудсыг үнэлгээний тайланд хавсаргана.

5.6. Салбарын мэргэжилтнийг үнэлгээний ажилд татан оролцуулсан тохиолдолд гаргасан дүгнэлт, тодорхойлолт, мэдээлэл, нягтлах шалгалтын тайланг уг үнэлгээний тайланд хавсаргана.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 7566 дугаарт бүртгэв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 2 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ, ТӨЛБӨРИЙН АРГА, ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, 9.1.13 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.8.6 дахь заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10 дахь заалтыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.“Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г 1 дүгээр хавсралтаар, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”-ыг 2 дугаар хавсралтаар, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д-даалгасугай:

1/энэ тогтоолыг хэрэгжүүлэх талаар эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар шуурхай хангаж, чиглэл бүхий албан даалгавар хүргүүлэх;

2/анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас иргэн, даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хянахад ашиглаж байгаа удирдлага, мэдээллийн систем, программд өөрчлөлт оруулж хөгжүүлэх, нэвтрүүлэх;

3/Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь болон түүнд үндэслэсэн эрүүл мэндийн байгууллагуудын төсөв, тоо хэмжээнд хяналт тавих, төсвөөс давсан зардал төлөвлөхгүй байх, тус сангийн тэнцлийг хангаж, өр төлбөргүй

ажиллахад хяналт тавих ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

4/анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг эмнэлзүйн үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай, эрүүл мэндийн байгууллагын шатлал, хүний нөөцийн болон санхүүжилтийн бодлоготой уялдуулан шинэчлэх, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх боломжийг бүрдүүлэх;

5/“Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэх журам” болон “Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журам”-ыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг нийцүүлэн шинэчлэн батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

6/өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг шинэчлэхэд бүртгэлтэй 1500 хүн ам тутамд нэг эмч, нэг сувилагч ажиллуулах бүтцийн өөрчлөлтийг тусгах, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн орон тоог тусгах, иргэн амьдарч байгаа газрын байршлаасаа эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авах нөхцлийг 2026 онд багтаан үе шаттай бүрдүүлэх, хэрэгжүүлэх.

3.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга (Ц.Батбаатар)-д даалгах нь:

1/иргэн харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэх, санхүүжилтийг хүн амын бүртгэл, шилжилт хөдөлгөөний дагуу тооцон олгох цахим программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх, нэвтрүүлэх;

2/өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн нэхэмжлэлийг бодит цагийн горимоор хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу тусламж, үйлчилгээг худалдан авах;

3/өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний багцтай уялдуулан чанар, төлбөрийн хяналтын оновчтой аргуудыг ашиглан хяналт тавих, иргэн, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээг танин баталгаажуулах орчин үеийн дэвшилтэт аргыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

4/өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар, гэрээний шалгуур үзүүлэлтийг анхан шатны тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн аргын зорилт, шатлалын бодлого, хүний нөөцийн бодлого, эмийн үнийн хөнгөлөлтийн бодлоготой уялдуулан шинэчлэн батлуулах, хэрэгжүүлэх;

5/гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад энэ тогтоолын 1 дэх заалтад заасан журмын талаар сургалт, мэдээллийг цогцоор нь хүргэх

ажлыг зохион байгуулах;

6/Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь, түүнд үндэслэсэн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээг эрүүл мэндийн байгууллагуудтай төсөв, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлтийг тусган байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж, тус сангийн тэнцлийг хангаж, өр төлбөргүй ажиллах;

7/эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээний хэлцэлд орохоос татгалзсан, гэрээний төсвийг хүлээн зөвшөөрөөгүй, тогтоосон хугацаанд гэрээг байгуулаагүй эрүүл мэндийн байгууллагын нэхэмжлэлийг хүлээн авахгүй байх;

8/Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт нийцүүлэн байгуулсан тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээнд заасан тоо хэмжээ, төсвөөс хэтэрсэн нэхэмжлэлийг хүлээн авахгүй, урамшууллаас бусад гэрээний дүнгээс хэтэрсэн санхүүжилт олгохыг хориглох бөгөөд үүнийг зөрчсөн бол холбогдох албан тушаалтанд тухай бүрд нь хариуцлага тооцох;

9/энэ тогтоолын 2.6-д заасан сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн орон тоонд нийцүүлэн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн суурь зардлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналд үндэслэн журамд заасны дагуу тооцож, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх;

10/өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиус, хүн амын тоо, алслалт зэрэг хүчин зүйлд үндэслэн анхан шатны тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгох судалгааг хийж, газарзүйн коэффициентийг тодорхойлон танилцуулж, шийдвэрлүүлэх;

11/иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, журмын талаар гарын авлага, контент бэлтгэж, хэвлэл мэдээллийн бүх төрлийн арга, хэрэгслийг ашиглан сурталчлан таниулах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.

4.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгах нь:

1/өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь өөрийн үйлчлэх хүрээнийхээ иргэдийг бүртгэж, баталгаажуулах ажлыг 2026 оны 05 дугаар сарын 01-ний дотор зохион байгуулах;

2/өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв 1500 хүн ам тутамд нэг эмч, нэг сувилагч ажиллуулахаар хүний нөөцийг бүрдүүлж ажиллах;

3/эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн систем, программд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг хийх, иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээ тус бүрийг хурууны хээ болон бусад орчин үеийн дэвшилтэт аргыг ашиглан танин баталгаажуулж, бодит цагийн горимоор нэхэмжлэх;

4/иргэн, даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, тусламж үйлчилгээний багцтай холбоотой мэдээлэл болон энэ тогтоолын талаар үнэн зөв мэдээллээр хангаж, чанартай тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх;

5/Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь, түүнд үндэслэсэн гэрээнд заасан төсөв, тоо хэмжээг баримтлан ажиллах, орлогын дүнтэй уялдсан зардлыг төлөвлөн зарцуулж, өр, авлага үүсгэхгүй ажиллах.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд, энэ тогтоолыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг ажлын албаны дарга (Ц.Сарантуяа)-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

*Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2026 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн
01-р тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ
НЬ ХАРИУЦАХ ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС
ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

Хүснэгт 1.Нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ

Д/д	Хүн амын эрүүл мэндийн эрсдэлийн бүлэг		Хүн амын эрсдэлийн бүлгийн коэффициент	Хүн амын эрсдэлийн бүлгээр тооцсон, нэг иргэнд ногдох төлбөрийн хэмжээ	Хүн амын эрсдэлийн бүлгээр тооцсон, нэг иргэнд ногдох төлбөрийн хэмжээ ¹
	Насны бүлэг	Оршин суугаа газар			
1	5 хүртэлх нас	Гэр хороолол	3.0	138,621	159,948
2		Орон сууц	2.6	120,138	138,622
3	6-15 нас	Гэр хороолол	1.5	69,311	79,974
4		Орон сууц	1.4	64,690	74,642
5	16-49 насны эмэгтэйчүүд	Гэр хороолол	1.7	78,552	90,637
6		Орон сууц	1.6	73,931	85,306
7	30-60 насны эрэгтэйчүүд	Гэр хороолол	1.8	83,173	95,969
8		Орон сууц	1.7	78,552	90,637
9	61-74 нас	Гэр хороолол	1.9	87,793	101,300
10		Орон сууц	1.7	78,552	90,637
11	75-аас дээш нас	Гэр хороолол	2.2	101,655	117,295
12		Орон сууц	2.0	92,414	106,632
13	Бусад*	Гэр хороолол	1.1	50,828	58,648
14		Орон сууц	1.0	46,207	53,316
Дундаж төлбөрийн хэмжээ				83,173	95,969

Бусад* - 16-29 насны эрэгтэйчүүд, 50-59 насны эмэгтэйчүүд

¹ Тогтоолын 4 дэх заалтын 1, 2 дахь дэд заалтад заасан хүн амын бүртгэлээ баталгаажуулсан болон хүний нөөцийг бүрдүүлсэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд мөрдөнө.

Хүснэгт 2.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээний тохиолдолд суурилсан төлбөрийн хэмжээ

Д/д	Код	Тусламж, үйлчилгээний багц	Тусламж, үйлчилгээний нэр	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага	Сорьц тээвэрлэх болон лавлагаа шат руу илгээх
1	10000002	Өдрийн эмчилгээ	Өдрөөр үзүүлэх эмийн эмчилгээ	150,000		
2	10000007	Өдрийн эмчилгээ	Хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчин / J02-J04, J09-J11, J12-J18, J20, J31/	100,000		
3	10000008	Өдрийн эмчилгээ	Хүүхдийн халдварт бус суулгалт өвчин /K52.9/	60,000		
4	10000009	Өдрийн эмчилгээ	Өдрөөр үзүүлэх уламжлалт анагаах ухааны эмчилгээ	150,000		
5	10000001	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	Архаг үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээ	80,000		
6	10000006	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	Дагнасан сэргээн засахын тусламж, үйлчилгээ	100,000		
7	10000005	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ /цогц тусламж, үйлчилгээ/	Бусад гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	50,000		
8	10000003	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ /цогц тусламж, үйлчилгээ/	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ /Z51.5/	150,000		
9	10000004	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ /цогц тусламж, үйлчилгээ/	Эмнэлэгт ирэх боломжгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрсний дараах эх, нярай, хүүхдэд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ	100,000		

10	10214002	Багажийн шинжилгээ	Бүх төрлийн рентген оношилгоо 1 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	10,000	+	+
11	10214003	Багажийн шинжилгээ	Бүх төрлийн рентген оношилгоо 2 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү)	20,000	+	+
12	10201005	Багажийн шинжилгээ	Зурхний цахилгаан бичлэг	9,000	+	-
13	10213002	Багажийн шинжилгээ	Нүдний эмгэгийн багажийн оношилгоо (Харааны талбайн шинжилгээ, нүдний угийн фото зураг)	30,000	+	+
14	10214006	Багажийн шинжилгээ	Рентген харалт (Цээж, хэвлий)	10,000	+	+
15	10201009	Багажийн шинжилгээ	Ургийн зурхний цахилгаан бичлэг	30,000	+	+
16	10202004	Багажийн шинжилгээ	Хатуу дуран (хамар, чих, арьс, вүүдийн ламп)	30,000	+	+
17	10203002	Багажийн шинжилгээ	Хэт авиан оношилгоо	15,000	+	+
18	10102003	Бюхимийн шинжилгээ	АЛАТ тодорхойлох	3,000	+	-
19	10102004	Бюхимийн шинжилгээ	Альбумин	3,000	+	+
20	10102006	Бюхимийн шинжилгээ	Амилаза	5,000	+	+
21	10102009	Бюхимийн шинжилгээ	Антистрептолизин О тест (ASLO /ASO) (тоогоор)	10,000	+	+
22	10102010	Бюхимийн шинжилгээ	АСАТ тодорхойлох	3,000	+	-
23	10102011	Бюхимийн шинжилгээ	Бага нягтралтай липопротеин	10,000	+	+
24	10102013	Бюхимийн шинжилгээ	Билирубин нийт	3,000	+	-
25	10102014	Бюхимийн шинжилгээ	Билирубин шууд	3,000	+	+
26	10102015	Бюхимийн шинжилгээ	Билирубин шууд бус	3,000	+	+
27	10102018	Бюхимийн шинжилгээ	Гаммаглутамилтрансфераза (ГТТ)	3,000	+	+
28	10102027	Бюхимийн шинжилгээ	Их нягтралтай липопротеин	6,000	+	+

29	10102028	Биохимийн шинжилгээ	Кали		5,000	+	+
30	10102030	Биохимийн шинжилгээ	Кальци		4,000	+	+
31	10102035	Биохимийн шинжилгээ	Креатинин (сийвэн болон шээсэнд)		4,000	+	-
32	10102043	Биохимийн шинжилгээ	ЛДГ		4,000	+	+
33	10102046	Биохимийн шинжилгээ	Липаза		6,000	+	+
34	10102047	Биохимийн шинжилгээ	Липопротейн А		8,000	+	+
35	10102048	Биохимийн шинжилгээ	Магни		4,000	+	+
36	10102052	Биохимийн шинжилгээ	Мочевин		4,000	+	+
37	10102055	Биохимийн шинжилгээ	Натри		5,000	+	+
38	10102057	Биохимийн шинжилгээ	Нийт уураг		3,000	+	-
39	10102066	Биохимийн шинжилгээ	Ревматоид фактор /RF/ (тоогоор)		9,000	+	+
40	10102067	Биохимийн шинжилгээ	С урвалжит уураг		11,000	+	+
41	10102070	Биохимийн шинжилгээ	Төмөр		4,000	+	+
42	10102072	Биохимийн шинжилгээ	Триглицерид		3,000	+	+
43	10102075	Биохимийн шинжилгээ	Фосфор		3,000	+	+
44	10102079	Биохимийн шинжилгээ	Хлор		5,000	+	+
45	10102081	Биохимийн шинжилгээ	Холестрин		3,000	+	-
46	10102097	Биохимийн шинжилгээ	Цусанд сахар үзэх (өглөөний өлөн цусанд тодорхойлох)		3,000	+	-
47	10102086	Биохимийн шинжилгээ	Шүлтлэг фосфатаза (ШФ)		4,000	+	+
48	10102091	Биохимийн шинжилгээ	Шээсний хүчил (цус)		3,000	+	+

49	10101003	Бичил амь судлалын шинжилгээ	Бичил биетэн өсгөрөлж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ (шарх, хамар, хамар залгиур, залгиур, чих, нүд, умайн хүзүү, шээсний сүв, үтрээ, өгтөн, идээ, булгаа, цэр, шээс, гуурсны арчдас (трахеостом, интубац, хэвлий, цээж, давсаг, ЭДВ-н болон бусад гуурс) хатгалтын шингэн, цэр бронхийн угаасны нян судлалын шинжилгээ (хэвлий, плевр, тархи нугасны шингэн, үений шингэн, олгой цес)	32,000	-	+
50	10101005	Бичил амь судлалын шинжилгээ	Шинжлэгдэхүүнийг будаж шинжлэх- Граммын будгийн арга	10,000	-	+
51	10104005	Гематологийн шинжилгээ	Улаан эсийн тунах хурд тодорхойлох	4,500	+	+
52	10104008	Гематологийн шинжилгээ	Цусны ерөнхий шинжилгээ	14,000	+	-
53	10105038	Иммуно гематологийн шинжилгээ	Сөрөг Резус Д баталгаажуулах	7,000	-	+
54	10105044	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны бүлэг, резус	11,000	+	-
55	10105045	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны резус бүлэг тодорхойлох (Rh фактор), баталгаажуулах	6,000	-	+
56	10106112	Иммунологийн шинжилгээ	Глюкозжсон гемоглобин	17,000	+	+
57	10106122	Иммунологийн шинжилгээ	Ийдэсний С урвалжийн уураг (CRP) электрохимилуминесценц	45,000	-	+
58	10106243	Түргэвчилсэн оношлуур	HBV хурдавчилсан сорил	6,000	+	-
59	10106244	Түргэвчилсэн оношлуур	HCV хурдавчилсан сорил	6,000	+	-
60	10106247	Түргэвчилсэн оношлуур	Амьсгалын замын халдварыг илрүүлэх түргэвчилсэн оношлуур	6,000	+	-
61	10106254	Түргэвчилсэн оношлуур	Жирэмсэн илрүүлэх түргэвчилсэн оношлуур	3,500	+	-
62	10102021	Түргэвчилсэн оношлуур	Сахарын түргэвчилсэн оношлуур	3,000	+	-
63	10106251	Түргэвчилсэн оношлуур	Стафилококкийн хурдавчилсан сорил	6,000	+	-

64	10106252	Түргэвчилсэн оношлуур	Стрептококийн хурдавчилсан сорил	6,000	+	-
65	10106248	Түргэвчилсэн оношлуур	Суулгалтат халдварын илрүүлэх	6,000	+	-
66	10113027	Түргэвчилсэн оношлуур	Өгтөнд далд цус тодорхойлох	6000	+	-
67	10106014	Түргэвчилсэн оношлуур	Сүрьеэгийн эсрэг биеийн шинжилгээ (anti TB cassette)	9,000	+	-
68	10106167	Түргэвчилсэн оношлуур	Тропонин (Troponin cassette)	25,000	+	-
69	10106172	Түргэвчилсэн оношлуур	Тэмбүүгийн хурдавчилсан сорил	5,000	+	-
70	10106246	Түргэвчилсэн оношлуур	ХДХВ хурдавчилсан сорил	6,000	+	-
71	10106253	Түргэвчилсэн оношлуур	Холестрины түргэвчилсэн оношлуур	3,000	+	-
72	10108024	Түргэвчилсэн оношлуур	Хүний папилома вирус (HPV) тодорхойлох хурдавчилсан аргын шинжилгээ	15,000	+	-
73	10106249	Түргэвчилсэн оношлуур	Хеликобактер илрүүлэх (Өгтөнд)	6,000	+	-
74	10110014	Түргэвчилсэн оношлуур	Шимэгч хорхойн өндөг илрүүлэг / Хурдавчилсан оношлуур/	8,000	+	+
75	10109001	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	АРТТ	5,000	+	+
76	10109005	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	Fibrinogen	6,000	+	+
77	10109012	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	ТТ	5,000	+	+
78	10109019	Цус бүлэгнэлтийн шинжилгээ (коагулограмм)	PT (INR)	5,000	+	+
79	10110013	Шимэгч судлалын шинжилгээ	Шимэгч хорхойн өндөг илрүүлэг /натив харах/	5,000	+	-
80	10112007	Эд эсийн шинжилгээ	Умайн хүзүүний эсийн шинжилгээ авах (ПАП сорил)	10,000	+	+

81	10112004	Эд эсийн шинжилгээ	Цитологи шинжилгээ	10,000	-	+
82	10113024	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Туузан оношлуураар (хэмжээ, хувийн жин, рН, уураг, улаан эс, нитрит, сахар, уробилиноген, цагаан эс, кетон)	6,000	+	+
83	10113019	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Шээсний ерөнхий шинжилгээ	6,000	+	+
84	10113025	Эмнэлзүйн химийн шинжилгээ	Шээсний тунадаснаас наац бэлтгэж микроскопоор шинжлэх (техниктэй бол)	8,000	+	+

*Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2026 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн
01-р тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ
ТӨЛБӨРИЙН АРГА**

1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дараах төлбөрийн аргаар санхүүжүүлнэ:

1.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад багтсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар;

1.2.сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх дараах эмнэлгийн тусламж, үйлчилгээг, лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх багц, төлбөрийн аргын дагуу тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар:

1.2.1.түргэн тусламжийн үйлчилгээ;

1.2.2.яаралтай тусламж, үйлчилгээ;

1.2.3.хэвтүүлэн эмчлэх зарим тусламж, үйлчилгээ;

1.2.4.дараах амбулаторийн тусламж, үйлчилгээ:

1.2.4.1.хүүхдийн шүд амны хөндийн урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ;

1.2.4.2.шүдний тусламж, үйлчилгээ;

1.2.4.3.сүрьеэ өвчний хяналт;

1.2.4.4.эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ (Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/292 дугаар тушаалын дагуу хийгдэх “Бүлгийн сургалт”).

1.3.эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтад заасан дараах тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар:

1.3.1.зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ;

1.3.2.оношилгоо, шинжилгээ;

1.3.3.өдрийн эмчилгээ;

1.3.4.гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ.

2.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтад зааснаас бусад анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10 дахь заалтад заасны дагуу иргэн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамаарч авна.

3.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар болон тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засвар, байрны түрээсийн зардал ороогүй бөгөөд эдгээр зардлыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан жил бүрийн төсвийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан холбогдох журмын дагуу орон нутгийн төсвөөс эдийн засгийн ангиллаар санхүүжүүлнэ.

4.Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тухайн жилийн Эрүүл мэндийн даатгалын сангийн батлагдсан төсвийн хүрээнд дараах өөрчлөлтийн аль нэг нь бүрдсэн үед зайлшгүй шинэчилнэ:

4.1.Үндэсний статистикийн хорооноос зарласан жилийн эцсийн инфляцын сүүлийн хоёр жилийн түвшингүүдийн нийлбэр нь 10 хувиас дээш гарсан үед;

4.2.төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн үед;

4.3.ам долларын төгрөгтэй харьцах ханш өмнөх өөрчлөлтөөс хойш 20 болон түүнээс дээш хувиар өөрчлөгдсөн үед;

4.4.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн тогтолцооны үнэлгээ болон тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, чанар, үр дүнд хийсэн судалгаа, үнэлгээгээр эрүүл мэндийн салбарын зардал, үр ашигт нөлөөлөл илэрсэн үед.

*Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2026 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн
01-р тогтоолын гуравдугаар хавсралт*

**ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ
ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авахад энэ журмыг баримтална.

**Хоёр.Эрүүл мэндийн анхан шатны тусламж,
үйлчилгээний санхүүжилтийг тооцох**

**А.Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн
хэмжээг тооцох аргачлал**

2.1.Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг дараах эх үүсвэрийн нийлбэрээр тооцно:

2.1.1.суурь зардал;

2.1.2.нэг иргэнээр тооцсон санхүүжилт;

2.1.3.тохиолдлоор тооцсон эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт;

2.1.4.байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт;

2.1.5.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн

9.1.9 дэх заалтад заасан тусламж, үйлчилгээний санхүүжилт;

2.1.6.сум, тосгоны эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилт.

$$НС = СЗ + НИС + ЭТҮС + ТЗС + ТС + УС$$

Энд,

НС - тухайн сум,тосгоны эрүүл мэндийн төвийн нийт санхүүжилт

СЗ - сум,тосгоны эрүүл мэндийн төвийн суурь зардал

НИС - нэг иргэнээр тооцсон санхүүжилт

ЭТҮС - эмнэлгийн тусламж,үйлчилгээний санхүүжилт

ТЗС - байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт

ТС - Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан

тусламж,үйлчилгээний санхүүжилт

УС - гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилт.

2.2. Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь Монгол Улсын алслагдсан бүс нутагт амьдарч байгаа хүн амд тусламж, үйлчилгээ үзүүлэх өвөрмөц бүтэц гэж үзэж, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн суурь зардлыг хүн амын тооноос хамаарахгүйгээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх нэгжийг ажиллуулахтай холбоотой зардлаар тооцож гаргана.

$$CЗ = CXCЗ \times ГЗК \times ОНН$$

CXCЗ - СТЭМТ - ын стандарт, зэрэглэлтэй холбоотой хүний нөөцийн зардал
ГЗК - газар зүйн коэффициент

ОНН - орон нутгийн цалингийн нэмэгдлийн коэффициент

2.2.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн байршлын онцлогоос хамаарсан газарзүйн коэффициентийг дараах томъёог ашиглан тооцох бөгөөд дараах зүйлсийг харгалзана:

$$ГЗК_i = (W_{i1} * D_{si} + W_{i2} * R_{si} + W_{i3} * Pop_{si} + W_{i4} * S_{si}) + A$$

Энд,

ГЗК_i – газар зүйн коэффициент

W_{i1} – өрх, сум, тосгоны төвөөс аймгийн төв хүртэлх зайн харгалзах хувийн жин

D_{si} – өрх, сум, тосгоны алслалтаас хамаарсан индекс

W_{i2} – эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусын харгалзах хувийн жин

R_{si} – эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс

W_{i3} – эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний хүн амын тооны харгалзах хувийн жин

Pop_{si} – эрүүл мэндийн төвд бүртгэлтэй хүн амаас хамаарсан тэгш байдлын индекс²

W_{i4} – замын бартааны үзүүлэлтээс харгалзах хувийн жин

S_{si} – замын бартаанаас хамаарсан индекс

A – тэнцвэржүүлэгч коэффициент- 0.5.

2.2.2. Сум тосгоны эрүүл мэндийн төвийн байршлын онцлогоос хамаарсан газарзүйн коэффициентууд нь доор дурдсан хувийн жингээс бүрдэнэ:

2.2.2.1. W_{i1} - алслалт 20 хувь;

2.2.2.2. W_{i2} - үйлчлэх хүрээний радиус 30 хувь;

2.2.2.3. W_{i3} - хүн амын тэгш байдал 20 хувь;

2.2.2.4. W_{i4} - замын бартаа 30 хувь.

2.2.3. Алслалтын хэмжээг сум, тосгоны төвөөс харьяа аймгийн төв хүртэлх зайгаар (км) тооцно.

² Тэгш байдлын индекс нь “Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалтад” хүрэх Тогтвортой хөгжлийн зорилтын 3.8.2 дахь шалгуур үзүүлэлтийг хангах зорилгоор иргэдийн оршин байгаа газраас үл хамааран чанартай эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авах боломжийг бий болгосон зардлын тохируулагч тооцоолол юм.

2.2.4. Үйлчлэх хүрээний радиусыг тухайн эрүүл мэндийн байгууллагаас үйлчлэх хүрээний хамгийн алслагдсан зайн хэмжээгээр (км) тооцно.

2.2.5. Замын бартааг тухайн сум, тосгоны газар нутгийн далайн түвшнээс дээш өргөгдсөн өндрийн хэмжээгээр тооцно.

2.2.6. Алслалтаас хамаарсан индексийг тухайн сум, тосгоны алслалтыг нийт сум, тосгоны алслалтын дундаж зайнд харьцуулж тооцно. Томьёогоор илэрхийлбэл:

$$Ds_i = \frac{D_i}{D}$$

Энд,

Ds_i – алслалтын индекс

D_i – сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс аймгийн төв хүртэлх зай (км)

D – нийт сум, тосгоны дундаж алслалт (127 км)

2.2.7. Үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индексийг сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусыг нийт сум, тосгоны үйлчлэх хүрээний радиусын дундаж хэмжээнд харьцуулж тооцно. Томьёогоор илэрхийлбэл:

$$Rs_i = \frac{R_i}{R}$$

Энд,

Rs_i – үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс

R_{si} – эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний зай (км)

R – үйлчлэх хүрээний дундаж радиус (107 км)

2.2.8. Хүн амын тооноос хамаарсан тэгш байдлын индексийг нийт сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хамгийн их хүн амтайгаас тухайн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүртгэлтэй хүн амын тоог хасаж, нийт сум, тосгоны хүн амын дундаж тоонд харьцуулж квадрат зэрэгт дэвшүүлж тооцно. Томьёогоор илэрхийлбэл:

$$Pops_i = \left(\frac{Pop_m - Pop_i}{P} \right)^2$$

Энд,

$Pops_i$ – хүн амын тооноос хамаарсан тэгш байдлын индекс

Pop_m – Монгол Улсын хүн ам хамгийн ихтэй сумын хүн амын тоо

Pop_i – тухайн сум, тосгоны бүртгэлтэй хүн амын тоо

P – үйлчлэх хүрээний хүн амын дундаж (3141)

2.2.9. Замын бартаанаас хамаарсан индексийг тухайн сум, тосгоны газар нутгийн далайн түвшнээс дээш өргөгдсөн өндрийг нийт сум, тосгоны дундаж өндөрт харьцуулж тооцно. Замын

бартаанаас хамаарсан индексэд харгалзах хуваарилалтыг томъёогоор илэрхийлбэл:

$$Ss_i = \frac{S_i}{S}$$

Энд,

Ss_i – хүн амын тооноос хамаарсан индекс

S_i – тухайн сумын далайн түвшнээс дээш өргөгдсөн өндөр (м)

S – далайн түвшнээс өргөгдсөн өндрийн дундаж (1381 м)

2.3.Орон нутгийн цалингийн нэмэгдлийн коэффициентийг анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүрээр тооцно. Үүнд дараах нэмэгдэл багтана:

2.3.1.сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь бүтэц, үйл ажиллагааны стандартад заасан албан хаагчдын орон тоо, Засгийн газрын шийдвэрээр батлан гаргасан орон нутгийн нэмэгдэл;

2.3.2.орон нутаг болон алслагдсан дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа өрхийн эрүүл мэндийн төвийн албан хаагчдад Засгийн газрын шийдвэрээр баталсан орон нутгийн нэмэгдэл.

2.4.Нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилтийн хэмжээг хүн амын насны бүлэг, амьдарч байгаа орон байрны нөхцөлийн хүчин зүйлийг харгалзан ялгаатай тогтоосон тарифыг тухайн сумын эрүүл мэндийн төвд бүртгүүлсэн хүн амын тоо болон тухайн сумын архаг өвчний хяналтын коэффициентоор тус тус үржүүлж тооцно.

$$\text{НИС} = \sum_{k=0}^n \binom{n}{k} \text{ХАК} \times \text{ТАР} \times \text{АӨХК}$$

НИС – нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилт

ХАК – хүн амын эрсдэлийн бүлгийн коэффициент

ТАР – нэг иргэнд ногдох зардлын хэмжээ

АӨХК – архаг өвчний хяналтын коэффициент

2.4.1.Нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг энэ журмын 2.4-т заасан томъёогоор тооцоход архаг өвчин, сүрьеэгийн хяналтын талаарх эрүүл мэндийн даатгалын цахим мэдээллийн санд баталгаажиж бүртгэгдсэн иргэн байвал харгалзах эрсдэлийн бүлгийн төлбөрийн хэмжээг 30 хувиар нэмэгдүүлэн олгоно:

2.4.1.1.даатгуулагчид зайлшгүй үзүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээ, хяналт ба түүний үр дүнг дараа сард үнэлэх;

2.4.1.2.даатгуулагчид зайлшгүй үзүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээ, хяналт ба түүний үр дүнг хангалтгүй үнэлэгдсэн нөхцөлд тухайн сараас нэмэгдэлийг зогсоох;

2.4.1.3.хяналтаас хасагдсан иргэдийг 3 сар дараалан зайлшгүй үзүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээ, хяналтад бүрэн

хамрагдсан бол дараа сараас 30 хувиар нэмэгдүүлэн санхүүжүүлнэ.

2.4.2 Нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргыг хэрэгжүүлэхдээ бүртгүүлсэн хүн амын нас болон эрсдэлийн бүлэг бүрд тохирох тусламж, үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэлийн тоо хэмжээ болон түүний чанарын шалгуур үзүүлэлтийг гэрээнд тусгаж нэг иргэний гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилтийг олгох бөгөөд дараах нийтлэг зарчмыг баримталж, бусад холбогдох эрх зүйн баримт бичигтэй уялдуулан уг санхүүжилтийг нэмэгдүүлж болно:

2.4.2.1.0-5 насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, дархлаажуулалт, эрт илрүүлэг, эрүүл мэндийг дэмжих, гэрийн эргэлт, оношилгоо, эмчилгээ, хяналт, бусад шатлалын тусламж, үйлчилгээг чиглүүлэх, зохицуулах;

2.4.2.2.6-17 насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг, дархлаажуулалт, эрүүл мэндийн боловсрол олгох, гэрийн эргэлт, оношилгоо, эмчилгээ, хяналт, бусад шатлалын тусламж, үйлчилгээг чиглүүлэх, зохицуулах;

2.4.2.3.нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хяналт, гэр бүл төлөвлөлт, жирэмсний хяналт, эхийн хяналт, эрт илрүүлэг, эрүүл мэндийн боловсрол олгох, өвчний учир үзлэг, оношилгоо, эмчилгээ, хяналт, бусад шатлалын тусламж, үйлчилгээг чиглүүлэх;

2.4.2.4.эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг, эрүүл мэндийг дэмжих, хянах, эрүүл мэндийн боловсрол олгох, оношилгоо, эмчилгээ, хяналт, бусад шатлалын тусламж, үйлчилгээг чиглүүлэх, зохицуулах;

2.4.2.5.ахмад настны эрүүл мэндийн үзлэг, хяналт, чадамжийн алдагдал, гэрийн эргэлт, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, хяналт, бусад шатлалын тусламж, үйлчилгээг чиглүүлэх, зохицуулах;

2.4.2.6.архаг өвчин, сүрьеэгийн хяналт, менежмент, эрүүл мэндийг дэмжих, оношилгоо, эмчилгээ, бусад шатлалын тусламж, үйлчилгээг чиглүүлэх, зохицуулах;

2.4.2.7.бусад шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зорилт, түүний хэрэгжилт.

2.5.Бүртгүүлж баталгаажуулсан хүн амын тоонд тухайн орон нутагт байнга болон түр амьдарч буй иргэн³-ийг хамруулах бөгөөд явуулын иргэнийг оруулан тооцохгүй.

2.6.Тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэхээр тооцсон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу Эрүүл

³ Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсэгт заасны дагуу Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлээгүй боловч тухайн бүс нутагт 180 хоногоос дээш хугацаагаар амьдарч тусламж, үйлчилгээ авч байгаа иргэнийг хэлнэ.

мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн аргын дагуу тухайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авна.

2.7. Эрүүл мэндийн төвийн байрлаж байгаа байрны түлш, халаалт, цэвэр болон бохир ус, цахилгаан эрчим хүч, байрны түрээс зэрэг байр ашиглалтын зардлыг тухайн барилга байгууламжийн эзлэхүүн, өмнөх жилийн зардлын суурь түвшнийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа үнэ тарифын өөрчлөлттэй харьцуулан тооцох бөгөөд уг зардлыг орон нутгийн төсвөөс хариуцна. Байр ашиглалттай холбоотой зардал дараах орцоос бүрдэнэ:

- 2.7.1. түлш, халаалтын зардал;
- 2.7.2. цахилгаан эрчим хүчний төлбөр;
- 2.7.3. цэвэр, бохир усны төлбөр;
- 2.7.4. байрны түрээсийн төлбөр.
- 2.7.5. урсгал засвар.

2.8. Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтад заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс тогтоосон тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг баримтлах бөгөөд дараах тусламж, үйлчилгээний багцыг хамруулж, энэ журмын дөрөвдүгээр зүйлд заасан зохицуулалтаар санхүүжүүлнэ:

- 2.8.1. зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ;
- 2.8.2. гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ;
- 2.8.3. өдрийн эмчилгээ;
- 2.8.4. оношилгоо, шинжилгээ.

2.9. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилтийг тухайн тайлант хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасан чанарын шалгуур үзүүлэлт, 16 дугаар зүйлийн 16.1.13 дахь заалтад заасан урамшууллыг олгох журмын хүрээнд олгоно.

Б.Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн хэмжээг тооцох аргачлал:

2.10. Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилт нь улсын төсвөөс хариуцах нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилт болон Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт, гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилтийн нийлбэрээр тодорхойлогдох ба дараах томъёогоор илэрхийлэгдэнэ:

$$НС = НИС + ТС + УС$$

Энд,

НС – тухайн өрхийн эрүүл мэндийн төвийн нийт санхүүжилт

НИС – нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилт

ТС – Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9

– д заасан тусламж, үйлчилгээний санхүүжилт

УС – гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилт.

2.11.Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг энэ журмын 2.3 болон 2.4-т заасны дагуу, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтад заасан тусламж, үйлчилгээний санхүүжилтийг энэ журмын 2.13-т заасны дагуу тус тус тооцно.

2.12.Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн урамшууллын санхүүжилтийг тухайн тайлант хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасан чанарын шалгуур үзүүлэлт, 16 дугаар зүйлийн 16.1.13 дахь заалтад заасан урамшууллыг олгох журмын хүрээнд хэрэгжүүлнэ.

В.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээг тооцох аргачлал

2.13.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн төвд хамаарах нийт хүн амын тоо болон үзүүлэх тусламж, үйлчилгээний нэг хүнд ногдох дундаж зардлын хэмжээгээр тодорхойлох ба дараах томъёогоор илэрхийлэгдэнэ:

$$ТС = (Pop_t \times C3_a) + (Pop_t \times GYTY_a) + (Pop_t \times \Theta A_a) + (Pop_t \times OШ_a)$$

Энд,

ТС – Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9 –

д заасан тусламж, үйлчилгээний санхүүжилт

Pop_t – эрүүл мэндийн төвд хамаарах нийт хүн амын тоо

$C3_a$ – зарим сэргээн засах үйлчилгээний нэг хүнд ногдох дундаж зардал

$GYTY_a$ – гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний нэг хүнд ногдох дундаж зардал

ΘA_a – өдрийн эмчилгээний нэг хүнд ногдох дундаж зардал

$OШ_a$ – оношилгоо, шинжилгээний нэг хүнд ногдох дундаж зардал.

2.14.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээний нэг хүнд ногдох дундаж зардлын хэмжээг хүн амын эрүүл

мэндийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн батлагдсан төсвийн дагуу тооцно.

Гурав.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх, хяналт тавих

3.1.Өрх, сумын эрүүл мэндийн төв өөрийн оршин байгаа газар нутгийн үйлчлэх хүрээний хүн амын бүртгэлийг цахим системд бүртгэх бөгөөд тухайн хүн ам, өрх, гэр бүлийн баталгаажуулсан байдалд үндэслэж нэг иргэнээр тооцсон санхүүжилт олгох хүн амыг сар бүр цахим системээр тодорхойлох ба ийнхүү тодорхойлохдоо дараах зохицуулалтыг дагаж мөрдөнө:

3.1.1.бүртгэлийг өрх, гэр бүлийн ам бүлийн бүртгэлд суурилан цогцоор нь хийх бөгөөд гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн баталгаажуулалт доор цахим системийн дагуу хэрэгжүүлэх;

3.1.2.түр амьдарч буй иргэнийг бүртгэн баталгаажуулсан мэдээллийг үндэслэн цахим системд бодит цагийн горим⁴-оор бүртгэсний дараагийн сараас эхлэн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг олгох;

3.1.3.шинээр төрсөн хүүхдийг эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн зөвшөөрлөөр цахим системд тухай бүр бүртгэж нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг дараагийн сараас олгох;

3.1.4.нас барсан иргэнийг нас барсны гэрчилгээнд үндэслэн цахим системд бүртгэх бөгөөд бодит цагийн горимд үндэслэн дараагийн сараас нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг зогсоох;

3.1.5.бичиг баримтгүй, харьяалал, бүртгэлгүй иргэний холбогдох байршил, амьдарч байгаа нөхцөл зэрэг холбогдох баримт бичгийг цахим системээр дамжуулан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс хүсэлт илгээх бөгөөд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар баталгаажуулсны үндсэн дээр нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг дараагийн сараас эхлэн санхүүжүүлэх.

3.2.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл хурлаараа батлах ба тухайн төсвийн нарийвчилсан хуваарийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга тушаалаар баталгаажуулан аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

3.3.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт тухайн орон нутгийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд хуваарилсан санхүүжилтийн зарлагын сарын хуваарийг хүргүүлнэ.

⁴ Тухайн цаг хугацаанд иргэнийг бүртгэн баталгаажуулж эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээхийг ойлгоно.

3.4.Энэ журмын 2.1, 2.7-д заасан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нийт санхүүжилтэд багтсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилтээс бусад тусламж, үйлчилгээний нэр, төрөл бүр дээр Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар байгуулна.

3.5.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээнд тусгасан дүнгээр холбогдох хуульд заасны дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийн хуваарийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн хүрээнд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.6.Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд шилжүүлэхийг хориглоно.

3.7.Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.10 дахь хэсэгт заасан сумын нэгдсэн эмнэлгийг, тухайн суманд үйл ажиллагаа явуулж байгаа өрхийн эрүүл мэндийн төв нь бүртгэлтэй хүн амаар нэг иргэнээр тооцсон санхүүжилт авсан бол нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар давхардуулан санхүүжүүлэхгүй.

3.8.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд хуваарилсан санхүүжилтийг зориулалтын бус хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.

3.9.Өрхийн эрүүл мэндийн төв төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг эдийн засгийн ангилал, зориулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр гаргаж, дараа сарын 05-ны дотор аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Төрийн санд хүргүүлнэ.

3.10.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг доор дурдсан үе шатын дагуу хянаж, санхүүжилтийг олгоно:

3.10.1.өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийг эрүүл мэндийн даатгалын цахим системд бодит цагийн горимоор илгээх;

3.10.2.эрүүл мэндийн даатгалын байгууллага өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэлд гэрээний шалгуур үзүүлэлтийн дагуу сар бүрийн эцэст цахим хэлбэрээр үнэлгээ хийж, дараа сарын 20-ны дотор

“гүйцэтгэлд суурилсан санхүүжилт”-ийг олгох;

3.10.3.нэг иргэний гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилтийн шалгуурыг хангасан эрүүл мэндийн байгууллагад сар бүр олгох;

3.10.4.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан болон бусад холбогдох хяналт, үнэлгээний аргыг ашиглаж болно.

3.11.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн анхан шатны тусламж, үйлчилгээний багц, нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн гүйцэтгэлийг үнэлж, санхүүжилтийг олгох зохицуулалтыг дараах зарчмын дагуу тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ, түүний шалгуур үзүүлэлт, гэрээг дүгнэх тухай холбогдох хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлнэ:

3.11.1.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв тус бүрийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 20 хүртэлх хувьтай тэнцэх дүнг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг үнэлэн санхүүжүүлэх;

3.11.2.нэг иргэний гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилтийн шалгуур үзүүлэлтэд нэг иргэнээр тооцсон төлбөрийн арга, багцтай уялдуулан зайлшгүй гүйцэтгэх шаардлагатай, анхан шатны тусламж, үйлчилгээний үр дүн, хариуцлагатай байдлыг хянах зорилго бүхий шалгуур үзүүлэлт байх бөгөөд дараах зарчмын хүрээнд хэрэгжинэ:

3.11.2.1.бүртгэлтэй хүн амын эрүүл мэндийн байдлыг үнэлж, эрсдэлийг тодорхойлох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох (хүүхдийн үзлэг, насан хүрэгчид, ахмад настан ICOPE, зорилтот бүлгийн үнэлгээ, бусад өвөрмөц үнэлгээ);

3.11.2.2.эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих, эрсдэлийг бууруулах арга хэмжээ;

3.11.2.3.товлолын дархлаажуулалт, жирэмсний хяналт, эх нярайн хяналт;

3.11.2.4.архаг өвчний хяналт;

3.11.2.5.шатлалын бодлого, “хаалга баригч”-ийн үүрэг гүйцэтгэх, бүртгэлтэй хүн амаа тогтмол хянаж, зайлшгүй шаардлагатай тохиолдлоос бусад үед лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээж байгаа иргэдийн тоог бууруулсан байдал;

3.11.2.6.зорилтот бүлгийн гэрийн эргэлт, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, хяналт;

3.11.2.7.бусад шаардлагатай үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт.

3.12.Анхан шатны суурь тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг үнэлж нэмэлт урамшуулал олгох зохицуулалтыг дараах нөхцөлийн дагуу тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ, түүний шалгуур

үзүүлэлт, гэрээг дүгнэх, урамшуулах тухай холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлнэ:

3.12.1.нэг иргэнээр тооцсон төсвийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагад бүрэн зарцуулах бөгөөд энэ журмын 3.11-д заасан нэг иргэний гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилтийн зөрүүг энэ журмын 3.12-т заасан гүйцэтгэлийн үнэлгээний нэмэлт урамшуулал хэлбэрээр олгох;

3.12.2.энэ журмын 3.12-т заасан урамшууллыг гэрээнд заасан чанар, үр дүнгийн шалгуур хангасан байгууллагад нэг иргэнээр тооцсон төсвийн 20 хүртэлх хувиар нэмэгдүүлэн урамшуулал хэлбэрээр олгох;

3.12.3.энэ журмын 3.12-т заасан урамшууллыг олгохдоо дараах чанар, үр дүнгийн зорилгод хүрсэн эсэхэд үндэслэж гэрээний дагуу шалгуур хангасан байгууллагад сар бүр тооцож олгох.

3.13.Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд нэг иргэнээр тооцсон төлбөрийн арга, багцтай уялдуулан зайлшгүй гүйцэтгэх шаардлагатай, анхан шатны тусламж, үйлчилгээний үр дүн, хариуцлагатай байдлыг хянах зорилго бүхий шалгуур үзүүлэлт байх бөгөөд дараах зарчмын хүрээнд хэрэгжинэ:

3.13.1.зайлшгүй шаардлагатай, туршлагатай хүний нөөц буюу эмчлэгч эмчийг 1000 хүн ам тутамд нэг эмч, нэг сувилагч байхаар бүрдүүлж, иргэнд ойр байршуулж ажилласан үр дүн;

3.13.2.эмч, эмнэлгийн мэргэжилтнийг анхан шатны тусламж, үйлчилгээний багцыг иргэдэд үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, мэргэжил, ур чадвар, хандлагын талаарх мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан байдал;

3.13.3.өрхийн эрүүл мэндийн төв томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеэр ажлын бус цагаар болон амралтын өдрүүдэд илүү цагаар иргэдэд хүрч, үр дүн гаргаж ажилласан байдал;

3.13.4.харьяаллын бус хүн амд үзүүлсэн анхан шатны тусламж, үйлчилгээний гүйцэтгэл;

3.13.5.эрүүл мэндийн үнэлгээ, өвчлөх эрсдэлд үндэслэн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан байдал (таргалалт, архи, тамхины хэрэглээ, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, сэтгэл зүйн зөвлөгөө гэх мэт).

3.14.Энэ журмын 3.12-т заасан урамшууллыг эрүүл мэндийн байгууллагад олгохдоо тухайн тайлант хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулсан эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тусгайлан олгож болно.

3.15.Энэ журмын 3.13.1-д заасан шалгуур үзүүлэлт нь өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцөд тавигдах стандарт болон тухайн өрхөд хамаарах бүртгэлтэй хүн амын тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг

хангаж байгаа байдал, тусламж, үйлчилгээ үзүүлсэн гүйцэтгэл, үр дүнг харгалзаж гэрээнд заасны дагуу дүгнэнэ.

3.16.Энэ журмын 3.13.2-т заасан шалгуур үзүүлэлтийг тооцохдоо эмч, эмнэлгийн мэргэжилтнийг өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцөд тавигдах стандарт, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд үндэслэсэн холбогдох байгууллагын албан ёсны мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамруулсан байдал, бүртгэлтэй хүн амын сэтгэл ханамжийн судалгаа зэрэгт үндэслэж хэрэгжүүлнэ.

3.17. Энэ журмын 3.13.3-д заасан шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Эрүүл мэндийн газраас албан ёсоор томуу, томуу төст өвчний дэгдэлтийг тодорхойлсон үед тооцох бөгөөд үүнд илүү цагаар ажиллах хугацаандаа тусламж, үйлчилгээ үзүүлсэн байдлыг ижил тэнцүү харгалзан холбогдох тооцооллыг хийж хэрэгжүүлнэ.

3.18.Энэ журмын 3.13.4-т заасан шалгуур үзүүлэлтийг тооцохдоо тухайн өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэлгүй хэдий ч анхан шатны тусламж, үйлчилгээг зайлшгүй шаардлагаар авсан тохиолдлын гүйцэтгэлд үндэслэж гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.

3.19.Энэ журмын 3.13.5-д заасан шалгуур үзүүлэлтийг тооцохдоо бүртгэлтэй хүн амын эрүүл мэндийн үнэлгээнд үндэслэн илрүүлсэн эрсдэлт хүчин зүйлийг бууруулж зохистой түвшинд хүргэсэн, үр дүнд хүрсэн бодит нотолгоонд үндэслэн суурь түвшин болон хүрэх түвшинг гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.

3.20.Гүйцэтгэлийн урамшууллыг цахим программ хангамжид үндэслэн хараат бус байдлаар дүгнэж, үр дүнг эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ил, тод нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

3.21.Орон нутгийн төсвөөс “гүйцэтгэлд суурилсан санхүүжилт”-д зориулан нэмэлт төсөв хуваарилж болно.

3.22.Байнгын оршин суугч гадаадын иргэн анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас анхан шатны суурь тусламж, үйлчилгээ авахаар хандсан бол нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн дүнг бүтэн жилээр тооцон төлж бүртгүүлэн тусламж, үйлчилгээ авч болно.

3.22.1.тус иргэд анхан шатны суурь тусламжаас бусад тусламж, үйлчилгээ авах шаардлага үүссэн бол өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжиж байгаа тусламж, үйлчилгээг тухайн батлагдсан тарифаар үзүүлнэ.

3.22.2.Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.4-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй даатгуулагч нь эрүүл мэндийн

тусламж, үйлчилгээ авахдаа тухайн тусламж, үйлчилгээний нийт төлбөрийн хэмжээний 80 хувьтай тэнцэх төлбөрийг эрүүл мэндийн байгууллагад төлнө. Монгол Улсаас бусад улстай байгуулсан Нийгмийн хамгааллын гэрээ, хэлэлцээрт эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудлыг тусгасан тохиолдолд тухайн гэрээ, хэлэлцээрийн зохицуулалтыг баримтална.

3.23.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу чанартай, чирэгдэлгүй үзүүлнэ.

3.24.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт заасныг үндэслэн иргэдэд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ төлбөр авахгүй.

3.25.Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн дагуу эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, арга хэмжээний зарим санхүүжилтийг холбогдох журмын дагуу санхүүжүүлэх бөгөөд нэг иргэнээр тооцсон санхүүжилттэй давхардуулахгүй.

3.26.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ дараах шаардлагыг хангаж ажиллана:

3.26.1.иргэн, даатгуулагчид тусламж, үйлчилгээг үзүүлэх бүрдээ тусламж, үйлчилгээ эхэлсэн болон дууссан хугацааг эрүүл мэндийн даатгалын цахим систем, программ хангамжид холбогдсон хурууны хээ болон бусад аргаар бүртгэж, баталгаажуулах;

3.26.2.эрүүл мэндийн даатгалын цахим систем, программ хангамжид холбогдож, мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангах;

3.26.3.даатгуулагчийн онош, нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд тохироогүй буюу шаардлагагүй тусламж, үйлчилгээг давхардуулан үзүүлэхгүй байх;

3.26.4.ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор даатгуулагчтай үгсэн хуйвалдах, буруу ташаа мэдээлэл өгөх, тулган шаардахгүй байх;

3.26.5.холбогдох баримт бичиг, бүртгэл, тайланг үнэн зөв мэдээлэх;

3.26.6.эмчлэх, сувилах, эм барих эрхийн зөвшөөрөлгүй этгээдийг үйл ажиллагаандаа татан оролцуулахгүй байх;

3.26.7.эрүүл мэндийн даатгалын байгууллага болон бусад холбогдох байгууллага, эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

3.27.Уул уурхай, дэд бүтцийн төслийн ажилтан, жуулчин, дотоодын цэрэг, хилийн цэргийн анги, хилийн боомтын албан хаагч, түүний хамт амьдарч байгаа гэр бүл болон хилээр нэвтэрч байгаа жолооч зэрэг харьяаллын бус иргэдэд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс анхан

шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх бөгөөд тэдгээр иргэдийн ажил олгогч, үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгж, хувь хүний зүгээс тухайн шатны Засаг дарга, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй тохиролцон гэрээ байгуулан нэмэлт санхүүжилт олгож болно.

3.28.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрөөс нэмэлт санхүүжилт болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс хуулиар хориглоогүй хандив, тусламж авч болох ба холбогдох хууль, журамд заасны дагуу тайлагнана.

Дөрөв.Өрх, сум, тосгоны эрүүл мэнд төвд зарим сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээг санхүүжүүлэх, хяналт тавих журмын зохицуулалт

Тусламж, үйлчилгээний төрөл	Багцыг тооцох	Тохиолдлын тоог хязгаарлах нөхцөл	Нэгж тохиолдолд хамаарах зардлын бүрэлдэхүүн
1.Зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ	Тусламж, үйлчилгээний 5-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзэх ба шаардлагатай тохиолдолд өвчний оношоос хамааруулан нэг даатгуулагчид 5 ба түүнээс дээш хоногоор тусламж, үйлчилгээг үзүүлж болно.	Даатгуулагчид сэргээн засахын багцын тусламж, үйлчилгээг үзүүлж байх хугацаандаа тухайн оношоор хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон санхүүжүүлнэ. Нэг даатгуулагчид шаардлагагүй олон тоогоор удаа дараа үзүүлсэн, цахим систем дээр сэжигтэй нэхэмжлэл ирсэн бол тухайн нэхэмжлэлийг түдгэлзүүлэн чанар, төлбөрийн хяналтаар хянасны үндсэн дээр санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.	Сэргээн засахын багцын зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо, дасгал, эмчилгээ, сувिलाхуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.
	Багцыг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт	1.1.Багц тусламж, үйлчилгээг үзүүлэх бүрд тухайн өдрийн эхэлсэн болон дууссан цагийг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдсон хурууны хээ болон бусад аргаар бүртгэн баталгаажуулна. 1.2.Багц тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаал, удирдамжийн дагуу үзүүлсэн сэргээн засах тусламж, үйлчилгээг санхүүжүүлнэ. 1.3.Дагнасан сэргээн засахын тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь мэргэшсэн сувилалчтай байх бөгөөд сэргээн засахын эмч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч нь гэрээт хэлбэрээр ажиллаж болно.	

	<p>Тусламж, үйлчилгээний 5-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзэх ба шаардлагатай тохиолдолд өвчний оношоос хамааруулан нэг даатгуулагчид 10 ба түүнээс дээш хоногоор тусламж, үйлчилгээг үзүүлж болно.</p>	<p>Даатгуулагчид тухайн багцын тусламж, үйлчилгээ үзүүлж байх хугацаандаа тухайн оношоор хэвтүүлэн эмчлэх тасарт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон санхүүжүүлнэ.</p> <p>Нэг даатгуулагчдад шаардлагагүй олон тоогоор удаа дараа үзүүлсэн, цахим систем дээр сэжигтэй нэхэмжлэл ирсэн бол тухайн нэхэмжлэлийг түдгэлзүүлэн чанар, төлбөрийн хяналтаар хянасны үндсэн дээр санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.</p> <p>Уламжлалт анагаах ухааны гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээг уламжлалт анагаах ухааны эмчийн үзлэг, оношилгоо хийсний үндсэн дээр уламжлалт анагаах ухааны эмч, эсхүл сувилагч тусламж, үйлчилгээ үзүүлж болно.</p>	<p>Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд эмчилгээ хийх хугацааны эмчийн үзлэг, зөвлөгөө, оношилгоо, засал, дасгал, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>
<p>2. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ</p>	<p>Уламжлалт анагаах ухааны эмчийн 5-аас дээш хоног үзүүлсэн гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээг нэг багц гэж үзнэ.</p>	<p>Уламжлалт анагаах ухааны оношилгоо (асуух, үзэх, хүрэлцэх), Эмчилгээ: Хувь хүний өвөрмөц чанар, цаг улиралд нь тохирсон идээ ундаа, амьдралын хэв маягийн талаарх зөвлөгөө, 3-аас доошгүй эм тан, засал эмчилгээ болон бусад холбогдох зардал хамаарна.</p>	
	<p>Багцыг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<p>2.1. Эрүүл мэндийн байгууллагад ирж тусламж, үйлчилгээ авах боломжгүй, хэвтрийн, хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ шаардлагатай бусад эмзэг бүлгийн даатгуулагчид цогц тусламж, үйлчилгээг үзүүлнэ.</p> <p>2.2. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг цогц байдлаар үзүүлснийг нэг тохиолдлоор тооцож санхүүжүүлэх бөгөөд тусламж, үйлчилгээний онцлогоос хамаарч гэрт очиж тусламж, үйлчилгээг үзүүлэх тоо нь байдлаас хамаарч харилцан адилгүй байна.</p> <p>2.3. Төрсний дараах эхийн 42 хоногийн эргэлтийг нярайн гэрийн эргэлттэй хамтад нь 1 багц болгож санхүүжүүлэх бөгөөд төрсний дараах 2 сарын хугацаанд 5-аас доошгүй удаа цахимаар (и даатгал апп) болон гэрээр хослуулан хянасан байна.</p> <p>2.4. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тээвэр, шатахууны зардлыг нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн газарзүйн индексээр зохицуулна.</p>	

<p>3.Өдрийн эмчилгээ</p>	<p>Зөвхөн 0-18 насны хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчин, халдварт бус суулгалт өвчний тусламж, үйлчилгээний 3-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзнэ.</p> <p>Бусад даатгуулагчийн тусламж, үйлчилгээний 5-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзнэ.</p>	<p>1.Даатгуулагчид өдрийн эмийн эмчилгээ үзүүлж байх хугацаанд тухайн оношоор нь хэвтүүлэн эмчлэх тасагт шилжүүлэн, хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд зөвхөн хэвтүүлэн эмчлэх үеийн зардлыг холбогдох оношийн хамааралтай бүлгээр нь тооцон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.</p> <p>2.Архаг өвчний үед хийх өдрийн эмчилгээг тухайн даатгуулагчид улиралд нэгээс илүүгүй байна.</p> <p>3.Нэг даатгуулагчид шаардлагагүй олон тоогоор удаа дараа тусламж, үйлчилгээ үзүүлсэн, ижил төстэй тусламж, үйлчилгээг өөр төрлийн эрүүл мэндийн байгууллагаас авсан, цахим систем дээр сэжигтэй нэхэмжлэл ирүүлсэн бол тухайн нэхэмжлэлийг түдгэлзүүлэн чанар, төлбөрийн хяналтаар хянасны үндсэн дээр санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.</p>	<p>Өдрийн эмийн эмчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийгдэх хугацааны туршид хэрэглэгдэх бүх төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, сувилгахуйн тусламж, үйлчилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна</p>	<p>Уламжлалт анагаах ухааны оношилгоо (асуух, үзэх, хүрэлцэх). Эмчилгээ: Хувь хүний өвөрмөц чанар, цаг улиралд нь тохирсон идээ ундаа, амьдралын хэв маягийн талаарх зөвлөгөө, 3-аас доошгүй эм тан, засал эмчилгээ болон бусад холбогдох зардал хамаарна.</p>	<p>3.1.Зөвхөн 0-18 насны хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчний тусламж, үйлчилгээний 3-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзэн “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-ний хүснэгт 2-ын 3-т зааснаар санхүүжүүлнэ.</p> <p>3.2.Зөвхөн 0-18 насны хүүхдийн халдварт бус суулгалт өвчний тусламж, үйлчилгээний 3-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзэн “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-ний хүснэгт 2-ын 4-т зааснаар санхүүжүүлнэ.</p> <p>3.3.Уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээний багцад хамаарах засал эмчилгээнд зөөлөн, эсхүл ширүүн заслын аль нэгийг гол үйлдэл болгон хийсэн байна.</p>	<p>Уламжлалт анагаах ухааны эмчийн 5-аас дээш хоног үзүүлсэн өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг нэг багц гэж үзнэ.</p>	<p>Багцыг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>
--------------------------	--	--	---	--	---	--	---

		<p>3.4.Багц тусламж, үйлчилгээг үзүүлэх бүрд тухайн өдрийн эхэлсэн болон дууссан цагийг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдсон хурууны хээ болон бусад аргаар бүртгэн баталгаажуулна.</p> <p>3.5.Өдрийн эмийн эмчилгээний нийт тохиолдлын 40%-аас доошгүйг хүүхдийн өдрийн эмчилгээ үзүүлсэн байна.</p> <p>3.6.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, жагсаалт"-д заасан өдрийн эмчилгээний оношийн хүрээнд санхүүжүүлнэ.</p>	
<p>4.Оношилгоо, шинжилгээ</p>	<p>Даатгуулагчид сард 40,000 төгрөг хүртэлх, жирэмсэн эмэгтэйд улиралд 120,000 төгрөг хүртэлх шинжилгээг нэхэмжлэх боломжтой.</p>	<p>1.Нийтийг хамарсан аян хэлбэрээр, эсхүл сургууль, цэцэрлэгт элсэх, урьдчилан сэргийлэх үзлэгийг энэ багцаар санхүүжүүлэхгүй, зөвхөн хүн амынхаа нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан, гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн зорилгод туссан эрт илрүүлэгт хамаарна.</p> <p>2.Нэг даатгуулагчид шаардлагагүй олон тоогоор удаа дараа тусламж, үйлчилгээ үзүүлсэн, цахим систем дээр сэжигтэй нэхэмжлэл ирүүлсэн бол тухайн нэхэмжлэлийг түдгэлзүүлэн чанар, төлбөрийн хяналтаар хянасны үндсэн дээр санхүүжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.</p> <p>3.Анхан шатны болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн оношилгоо, шинжилгээг ашиглах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд давтан хийж нэхэмжлэх бөгөөд чанар, төлбөрийн хяналтаар шийдвэрлэнэ.</p>	<p>Бүх төрлийн лабораторийн шинжилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.</p>

	<p>Багцыг санхүүжүүлэхэд баримтлах зохицуулалт</p>	<p>4.1.Багц тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх оношилгоо, шинжилгээний жагсаалтын дагуу эмчийн заалтаар эрт илрүүлэх, өвчний учир онош тогтоолгох болон өвчний явцыг хянах зорилгоор үзүүлнэ.</p> <p>4.2.Даатгуулагчид хийгдсэн оношилгоо, шинжилгээний зардлыг “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-ний Хүснэгт 2-ын 9-аас 154-д заасан холбогдох төлбөрийн хэмжээгээр сард 40,000, өсхүл жирэмсэн эмэгтэйдүүдийн хувьд улиралд 120,000 төгрөгийн хязгаараас хэтрүүлэхгүйгээр нэхэмжилж болно.</p> <p>4.3.Оношилгоо, шинжилгээгээр өвчлөл илэрсэн эмчлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжийг хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу оношийн хамааралтай бүлгээр хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг санхүүжүүлж байгаа бөгөөд хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний өртөгт оношилгоо, шинжилгээний зардал багтсан байдаг тул хасаж тооцно.</p> <p>4.4.Багц тусламж, үйлчилгээг үзүүлэх бүрд тухайн өдрийн эхэлсэн болон дууссан цагийг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдсон хурууны хээ болон бусад аргаар бүртгэн баталгаажуулна.</p>
--	---	---

Тав.Талуудын эрх, үүрэг

5.1. Даатгуулагч дараах эрхтэй:

5.1.1.өрхийн эрүүл мэндийн төв болон өөрт ойр байгаа сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй багц тусламж, үйлчилгээг авах;

5.1.2.эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний болон эрүүл мэндийн даатгалын талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авах;

5.1.3.холбогдох хууль, журам, стандарт зөрчсөн, чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн төвийн талаар эрүүл мэндийн даатгалын байгууллага болон холбогдох хяналтын байгууллагад гомдол гаргах.

5.2.Даатгуулагч дараах үүрэгтэй:

5.2.1.иргэн өөрийн амьдарч байгаа харьяаллын дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллагад бүртгүүлэхдээ хурууны хээ болон орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан бүртгүүлэх хүсэлтээ баталгаажуулах;

5.2.2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18.1, 18.2 дахь хэсэгт заасны дагуу бүртгүүлээгүй иргэн өөрийн түр амьдарч байгаа газартайгаа ойр анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг сонгохдоо хурууны хээ болон орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан бүртгүүлэх хүсэлтээ баталгаажуулах;

5.2.3.эрүүл мэндийн төвөөс багц тусламж, үйлчилгээ авах бүрд өөрийн хурууны хээг уншигч төхөөрөмжөөр уншуулах, хэрвээ хурууны хээг уншуулах боломжгүй тохиолдолд асран хамгаалагчийн хурууны хээ болон бусад аргаар бүртгэн баталгаажуулах;

5.2.4.даатгалын байгууллага, эрүүл мэндийн төв, эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, шаардлагагүй тусламж, үйлчилгээг давхардуулан авахгүй байх;

5.2.5.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа иргэний үнэмлэх, бусад аргаар баталгаажуулж, холбогдох байгууллагаар хүндэтгэлтэй үйлчлүүлэх.

5.3.Эрүүл мэндийн төв дараах эрхтэй:

5.3.1.даатгуулагчид үзүүлсэн багц тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг батлагдсан төсвийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэх;

5.3.2.эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтны ёс зүй, харьцаа, хандлага, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол гаргах;

5.3.3.эрүүл мэндийн даатгалын байгууллага болон даатгуулагчид хууль ёсны шаардлага тавих;

5.3.4.даатгалын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох.

5.4. Эрүүл мэндийн төв дараах үүрэгтэй:

5.4.1. бүтэц, үйл ажиллагааны стандарт, өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамжийг баримтлан даатгуулагчид энэ журамд заасан багц тусламж, үйлчилгээг аюулгүй, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй цогц байдлаар үзүүлэх;

5.4.2. даатгуулагчид багц тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ даатгуулагчийн холбогдох мэдээлэл болон анхан шатны бүртгэлийг цахим хэлбэрээр үнэн зөв, бүрэн гүйцэд хөтлөх, хадгалах, илгээх, НӨАТУС бүхий баримтыг олгох, зайлшгүй шаардлагаар цаасан хэлбэрээр хөтөлж болно;

5.4.3. эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдож, мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангах;

5.4.4. эрүүл мэндийн төвийн хаяг, байршил, талбайн хэмжээ, хүний нөөц, тоног төхөөрөмж, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээ, оношилгоо шинжилгээний төлбөрийн хэмжээг үнэн зөв мэдүүлэх, өөрчлөлт оруулсан тохиолдол бүрд албан бичгээр ажлын 7 өдрийн дотор эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдэгдэх;

5.4.5. даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, мэдээллээр хангах;

5.4.6. даатгуулагчийн онош, нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд тохироогүй буюу шаардлагагүй тусламж, үйлчилгээг давхардуулан үзүүлэхгүй байх;

5.4.7. эрүүл мэндийн даатгалын байгууллага болон бусад холбогдох байгууллага, эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

5.4.8. холбогдох эрх зүйн баримт бичигт зааснаас бусад төр хариуцах тусламж, үйлчилгээг нэхэмжлэхгүй байх.

5.5. Эрүүл мэндийн даатгалын байгууллага дараах эрхтэй:

5.5.1. эрүүл мэндийн төвийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан журмын дагуу сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн төвтэй даатгалын гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

5.5.2. эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, зардлын төлбөрт цахим болон цаасан хэлбэрээр хяналт тавих, дүгнэлт гаргах, зөвлөмж, заавар өгөх;

5.5.3. эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт болон зардлын хэмжээг судлах, үнэлэх, үр дүнг тооцох, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх;

5.5.4. Эрүүл мэндийн сайдын багцын батлагдсан урсгал төсөв болон олон улсын байгууллагын санхүүжилтээр эрүүл мэндийн байгууллагыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуураар хангасан тохиолдолд тухайн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуурын нийт зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас олговол зохих нийт төлбөрөөс хасаж санхүүжүүлэх;

5.5.5. Эрүүл мэндийн төв болон даатгуулагчид хууль ёсны шаардлага тавих.

5.6. Эрүүл мэндийн даатгалын байгууллага дараах үүрэгтэй:

5.6.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн төвийн хооронд мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангаж, цахим системд нэвтрэх эрх олгох, даатгуулагчид цахимаар мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх;

5.6.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлын тайланд дүн шинжилгээ хийх, судалгааны дүнг үндэслэн шаардагдах төсвийн хэмжээг тооцох, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх;

5.6.3. Эрүүл мэндийн төв болон даатгуулагчаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, хуулийн дагуу шуурхай шийдвэрлэх, даатгалын харилцаанд оролцогч талуудыг мэдээллээр хангах;

5.6.4. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулах.

Зургаа.Хариуцлага

6.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтан, даатгуулагч холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Энэ журамд тусгагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн даатгалын гэрээгээр зохицуулна.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн баатгалын сангаас санхүүжүүлэх журмын хавсралт

ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ГАЗАРЗҮЙН КОЭФФИЦИЕНТ⁵

№	Аймаг, нийслэлийн нэр	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нэр	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс ($W_{12} * R_{st}$)	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн алслалтаас хамаарсан индекс ($W_{17} * D_{st}$)	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн замын бартаанаас хамаарсан индекс ($W_{14} * S_{st}$)	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүн амаас хамаарсан тэгш байдлын индекс ($W_{13} * Pop_{st}$)	Газарзүйн коэффициент $(W_{17} * D_{st} + W_{12} * R_{st} + W_{14} * S_{st}) + A$
1	Архангай	Батцэнгэл	0.93	0.71	1.03	3.58	1.95
2	Архангай	Булган	1.1	0.37	1.39	4.90	2.30
3	Архангай	Жаргалант	1.21	2.27	1.16	2.86	2.24
4	Архангай	Их тамир	1.1	0.27	1.21	1.70	1.59
5	Архангай	Өгийнуур	0.7	1	0.97	4.41	2.08
6	Архангай	Өлзийт	0.52	1.34	0.94	4.03	2.01
7	Архангай	Өндөр-Улаан	1.6	1.22	1.65	1.55	2.03
8	Архангай	Төвшрүүлэх	0.45	0.44	1.17	4.68	2.01
9	Архангай	Хайрхан	0.6	1.75	1.43	3.65	2.19
10	Архангай	Хангай	1.25	2.3	1.53	4.24	2.64
11	Архангай	Хашаат	0.8	1.78	0.93	4.29	2.23
12	Архангай	Хоршоолол	0.5	0.45	1.18	15.64	4.22

⁵ ГЗКг = $(W_{17} * D_{st} + W_{12} * R_{st} + W_{14} * S_{st} + Pop_{st} * W_{13}) + A$

13	Архангай	Хотонт	0.8	0.91	1.06	2.90	1.82
14	Архангай	Цахир	0.85	3.06	1.52	5.37	2.90
15	Архангай	Цэнхэр	1.6	0.29	1.53	1.37	1.77
16	Архангай	Цэцэрлэг	0.88	2.12	1.21	3.53	2.26
17	Архангай	Чулуут	0.65	1.27	1.47	3.13	2.02
18	Архангай	Тариат	1.1	1.66	1.26	2.30	2.00
19	Архангай	Эрдэнэмандал	1	1.65	1.26	1.69	1.85
20	Архангай	Мөнхжин ӨЭМТ					1.00
21	Архангай	Мөнгөнчагнуур ӨЭМТ					1.00
22	Архангай	Манал ӨЭМТ					1.00
23	Баян-Өлгий	Алтай	0.75	1.12	1.55	3.00	2.01
24	Баян-Өлгий	Алтанцөгц	0.9	0.43	1.36	4.72	2.21
25	Баян-Өлгий	Баяннуур	0.6	1.26	0.97	2.35	1.69
26	Баян-Өлгий	Бугат	1	0.05	1.41	3.42	1.92
27	Баян-Өлгий	Булган	0.7	2.94	1.41	2.16	2.15
28	Баян-Өлгий	Баянт	1.64	0.72	1.41	4.84	2.53
29	Баян-Өлгий	Сагсай	1.7	0.27	1.61	2.00	1.95
30	Баян-Өлгий	Толбо	1.5	0.76	1.38	3.01	2.12
31	Баян-Өлгий	Улаанхус	1.54	0.46	1.28	0.09	1.46
32	Баян-Өлгий	Хотгор	1.4	1.4	1.24	16.94	4.96
33	Баян-Өлгий	Цагааннуур	0.6	0.69	1.07	6.57	2.45
34	Баян-Өлгий	Дэлүүн	0.85	1.58	1.33	0.51	1.57
35	Баян-Өлгий	Ногооннуур	1	0.92	1.33	1.09	1.60
36	Баян-Өлгий	Цэнгэл	1.4	0.79	1.33	-	1.48
37	Баян-Өлгий	Жансая ӨЭМТ					1.00
38	Баян-Өлгий	Раушан ӨЭМТ					1.00
39	Баян-Өлгий	Мейрим ӨЭМТ					1.00

68	Булган	Бүрэгхангай	1.15	0.85	0.93	4.82	2.26
69	Булган	Гурванбулаг	0.6	1.5	0.79	4.21	2.06
70	Булган	Дашинчилэн	0.8	1.53	0.76	4.52	2.18
71	Булган	Могод	0.6	1.32	1.04	5.05	2.27
72	Булган	Орхон	0.8	0.22	0.77	3.79	1.77
73	Булган	Рашаант	0.4	2.25	0.99	4.28	2.22
74	Булган	Сайхан	0.5	1.01	1.07	3.81	1.93
75	Булган	Сэлэнгэ	2	1.2	0.55	4.21	2.35
76	Булган	Тэшиг	1.2	2.45	0.74	3.76	2.32
77	Булган	Хангал	0.65	1.1	0.75	6.82	2.50
78	Булган	Хялганат	0.7	1.3	0.75	4.62	2.12
79	Булган	Хишиг-Өндөр	1.5	1.5	0.84	4.57	2.42
80	Булган	Хутаг-Өндөр	0.65	0.7	0.84	2.22	1.53
81	Булган	Цоожэд ӨЭМТ					1.00
82	Булган	Эмийн цэцэглэн ӨЭМТ					1.00
83	Говь-Алтай	Алтай	1.42	3.6	1.57	5.90	3.30
84	Говь-Алтай	Баянгоорой	0.9	2.6	1.21	15.34	4.72
85	Говь-Алтай	Бугат	3.7	2.05	1.55	5.77	3.64
86	Говь-Алтай	Гуулин	0.4	0.9	1.24	16.40	4.45
87	Говь-Алтай	Дарви	0.8	2.1	1.17	6.38	2.79
88	Говь-Алтай	Дэлгэр	0.8	1	1.3	5.38	2.41
89	Говь-Алтай	Жаргалан	0.96	0.97	1.11	6.30	2.57
90	Говь-Алтай	Тайшир	0.7	0.45	1.19	6.60	2.48
91	Говь-Алтай	Тонхил	1.8	2.1	1.59	5.63	3.06
92	Говь-Алтай	Халиун	0.95	1.1	1.04	5.37	2.39
93	Говь-Алтай	Хөхморьт	1.1	2.15	1.04	5.50	2.67
94	Говь-Алтай	Цогт	1.2	2	1.66	5.25	2.81

95	Говь-Алтай	Цээл	1.3	1.8	1.5	5.63	2.83
96	Говь-Алтай	Чандмань	1.1	2.26	1.65	5.60	2.90
97	Говь-Алтай	Шарга	0.8	0.89	0.74	6.05	2.35
98	Говь-Алтай	Эрдэнэ	1.7	2.53	1.77	5.52	3.15
99	Говь-Алтай	Баян-Уул	1.8	1.5	1.33	4.52	2.64
100	Говь-Алтай	Бигэр	1.2	1.08	1.33	5.65	2.61
101	Говь-Алтай	Төгрөг	2	1.5	1.33	5.89	2.98
102	Говь-Алтай	Энх Алтай ӨЭМТ					1.00
103	Говь-Алтай	Жаргалан Алтай ӨЭМТ					1.00
104	Говь-Алтай	Марал Алтай ӨЭМТ					1.00
105	Говьсүмбэр	Баянтал	0.54	0.6	0.78	15.05	4.03
106	Говьсүмбэр	Шивээговь	0.72	0.86	0.81	3.53	1.84
107	Говьсүмбэр	Энхтүсдэм ӨЭМТ					1.00
108	Дархан-Уул	Орхон	0.4	1	0.46	4.24	1.81
109	Дархан-Уул	Хөнгөр	1.4	0.44	0.52	1.49	1.46
110	Дархан-Уул	Шарын гол	0.6	1.5	0.66	0.34	1.25
111	Дархан-Уул	Түвшинхолбоо ӨЭМТ					1.00
112	Дархан-Уул	Аминхолбоо ӨЭМТ					1.00
113	Дархан-Уул	Гэрэлтэй ӨЭМТ					1.00
114	Дархан-Уул	Гос хот ӨЭМТ					1.00
115	Дархан-Уул	Мөдс ТОВ ӨЭМТ					1.00
116	Дорноговь	Айраг	1.3	1.27	0.76	3.73	2.12
117	Дорноговь	Алтанширээ	1.3	0.9	0.7	14.16	4.11
118	Дорноговь	Даланжаргалан	1.84	1.56	0.89	4.55	2.54
119	Дорноговь	Дэлгэрэх	1.58	1.4	0.77	6.23	2.73
120	Дорноговь	Иххэт	1.62	1.8	0.87	5.91	2.79

121	Дорноговь	Мандах	1.92	1.75	0.84	6.73	3.02
122	Дорноговь	Өргөн	1.5	0.6	0.71	5.74	2.43
123	Дорноговь	Сайхандулаан	1.86	0.98	0.91	14.09	4.34
124	Дорноговь	Улаанбадрах	2.1	1.35	0.72	6.83	2.98
125	Дорноговь	Хатанбулаг	2.56	2.45	0.82	4.63	2.93
126	Дорноговь	Хөвсгөл	1.7	1.76	0.72	6.70	2.92
127	Дорноговь	Эрдэнэ	1.3	1.06	0.71	5.52	2.42
128	Дорноговь	Зүүнбаян	0.9	0.5	0.74	6.03	2.30
129	Дорноговь	Агапова ӨЭМТ					1.00
130	Дорноговь	Мишээлт мана ӨЭМТ					1.00
131	Дорноговь	Талст зам ӨЭМТ					1.00
132	Дорноговь	Борхойн наран ӨЭМТ					1.00
133	Дорнод	Баяндун	0.87	1.8	0.68	4.33	2.19
134	Дорнод	Баянтүмэн	2.2	0.15	0.55	4.94	2.34
135	Дорнод	Булган	1.2	0.6	0.56	5.94	2.34
136	Дорнод	Гурванзагал	0.8	1.3	0.51	6.79	2.51
137	Дорнод	Матад	2	1.5	0.65	4.28	2.45
138	Дорнод	Сэргэлэн	0.75	0.7	0.55	5.94	2.22
139	Дорнод	Хөлөнбуйр	0.8	1.3	0.61	6.17	2.42
140	Дорнод	Цагаан-Овоо	0.8	1.3	0.62	3.58	1.90
141	Дорнод	Чойбалсан	1.67	0.6	0.61	4.88	2.28
142	Дорнод	Чулуунхороот	0.8	2.65	0.44	6.20	2.64
143	Дорнод	Баян-Уул	0.75	2	0.58	2.46	1.79
144	Дорнод	Дашбалбар	0.9	1.8	0.58	3.95	2.09
145	Дорнод	Халхгол	2.1	3.6	0.58	4.15	2.85
146	Дорнод	Асралт үйлс ӨЭМТ					1.00

173	Завхан	Нөмрөг	0.8	1.52	1.33	6.14	2.67
174	Завхан	Отгон	2.5	1.28	1.55	5.11	2.99
175	Завхан	Сантмаргац	0.6	2.92	1.13	6.76	2.96
176	Завхан	Сонгино	0.53	2.32	1.31	6.81	2.88
177	Завхан	Тэлмэн	1.1	1.22	1.3	4.75	2.41
178	Завхан	Тэс	0.7	3.37	0.93	4.67	2.60
179	Завхан	Ургамал	0.9	2.36	0.92	14.29	4.38
180	Завхан	Цагаанхайрхан	1.3	0.44	1.31	14.17	4.21
181	Завхан	Цагаанчулуут	1.1	0.97	1.54	14.42	4.37
182	Завхан	Цэцэн-Уул	0.9	2.47	1.39	6.65	3.01
183	Завхан	Эрдэнэхайрхан	1.6	1.15	1.36	6.50	2.92
184	Завхан	Яруу	1.7	0.56	1.51	6.00	2.78
185	Завхан	Завханмандал	0.85	1.67	1.27	15.08	4.49
186	Завхан	Түдэвтэй	0.8	1.96	1.27	6.17	2.75
187	Завхан	Шилүүстэй	1.3	1.35	1.27	6.36	2.81
188	Завхан	Биндэргарав ӨЗМТ					1.00
189	Завхан	Дөрвөн оноо ӨЗМТ					1.00
190	Завхан	Мөнхийн алба ӨЗМТ					1.00
191	Орхон	Жаргалант	0.4	0.35	0.76	3.98	1.71
192	Орхон	Мөндцөн ӨЗМТ					1.00
193	Орхон	Учралтбаяр ӨЗМТ					1.00
194	Орхон	Анхны оч ӨЗМТ					1.00
195	Орхон	Энхжихмандирваа ӨЗМТ					1.00
196	Орхон	Мөнхсүндэрл ӨЗМТ					1.00
197	Орхон	Үйлсбадрах ӨЗМТ					1.00
198	Орхон	Мөнхийн гэгээ ӨЗМТ					1.00
199	Орхон	Нийцэл ӨЗМТ					1.00

200	Өвөрхангай	Баруунбаян-Улаан	0.56	1.75	0.91	4.88	2.27
201	Өвөрхангай	Бат-Өлзий	0.29	1.24	1.22	0.47	1.29
202	Өвөрхангай	Баянгол	0.3	0.8	1.05	3.52	1.77
203	Өвөрхангай	Баян-Өндөр	0.4	1.22	1.17	3.74	1.96
204	Өвөрхангай	Богд	0.8	1.97	1.1	1.56	1.78
205	Өвөрхангай	Бүрд	0.35	1.36	1.08	4.71	2.14
206	Өвөрхангай	Гучин-Ус	0.45	1.04	1.06	5.74	2.31
207	Өвөрхангай	Зүүнбаян-Улаан	0.48	0.47	1.34	3.48	1.84
208	Өвөрхангай	Нарийнтээл	0.45	1.35	1.31	3.77	2.05
209	Өвөрхангай	Өлзийт	0.32	0.88	1.35	5.45	2.27
210	Өвөрхангай	Сант	0.27	1	1.1	3.88	1.89
211	Өвөрхангай	Тарагт	0.57	0.35	1.1	4.29	1.93
212	Өвөрхангай	Төгрөг	0.8	0.95	1.02	4.95	2.23
213	Өвөрхангай	Уянга	0.6	0.61	1.44	0.00	1.23
214	Өвөрхангай	Хайрхандулаан	0.39	0.72	1.36	3.92	1.95
215	Өвөрхангай	Хужирт	0.2	0.84	1.2	0.86	1.26
216	Өвөрхангай	Есөнзүйл	1.21	1	1.15	4.78	2.36
217	Өвөрхангай	Нарны дөш ӨЗМТ					1.00
218	Өвөрхангай	Түшигдөлгөөн ӨЗМТ					1.00
219	Өвөрхангай	Уян сэтгэл ӨЗМТ					1.00
220	Өвөрхангай	Энэрэл Хархорин ӨЗМТ					1.00
221	Өмнөговь	Баяндалай	1.8	1.27	1.12	5.90	2.81
222	Өмнөговь	Баян-Овоо	1	0.9	0.86	6.29	2.50
223	Өмнөговь	Булган	2.4	1.56	0.59	5.93	2.89
224	Өмнөговь	Мандаг-Овоо	0.9	1.8	0.78	6.65	2.69
225	Өмнөговь	Манлай	1.8	1.75	0.94	5.03	2.68
226	Өмнөговь	Номгон	1.98	0.6	1.08	5.21	2.58

227	Өмнөговь	Сэврэй	1.28	0.98	1.23	5.99	2.65
228	Өмнөговь	Гурвантэс	3.1	1.4	1.25	2.07	2.50
229	Өмнөговь	Ханхонгор	1.15	1.35	0.91	6.07	2.60
230	Өмнөговь	Хүрмэн	2.04	2.45	1.32	6.74	3.35
231	Өмнөговь	Цогт-овоо	1.3	1.76	1.07	6.22	2.81
232	Өмнөговь	Ноён	2.71	2.16	1.01	14.09	4.87
233	Өмнөговь	Ханбогд	1.76	2.5	1.01	0.18	1.87
234	Өмнөговь	Цогтцэций	1.39	1	1.01	0.17	1.45
235	Өмнөговь	Шим билэг ӨЭМТ					1.00
236	Өмнөговь	Энхийн хүслэн ӨЭМТ					1.00
237	Өмнөговь	Өнө орших ӨЭМТ					1.00
238	Сүхбаатар	Асгат	1.1	0.48	0.75	6.12	2.38
239	Сүхбаатар	Баяндэлгэр	0.9	1.45	0.79	2.17	1.73
240	Сүхбаатар	Дарьганга	1.1	1.7	0.9	4.39	2.32
241	Сүхбаатар	Мөнххаан	1.1	1.08	0.89	2.34	1.78
242	Сүхбаатар	Наран	0.6	2.12	0.89	6.57	2.68
243	Сүхбаатар	Сүхбаатар	1.2	0.8	0.65	3.92	2.00
244	Сүхбаатар	Түвшинширээ	1.7	1.4	0.8	4.02	2.33
245	Сүхбаатар	Түмэнцогт	0.67	1.4	0.71	5.29	2.25
246	Сүхбаатар	Уулбаян	1.1	0.55	0.75	4.61	2.09
247	Сүхбаатар	Халзан	0.46	0.68	0.75	6.31	2.26
248	Сүхбаатар	Эрдэнэцагаан	2.6	2.2	0.78	0.81	2.12
249	Сүхбаатар	Онгон	1.5	1.65	0.79	3.47	2.21
250	Сүхбаатар	Энэрэл ачлан ӨЭМТ					1.00
251	Сүхбаатар	Энхлэн ачлан ӨЭМТ					1.00
252	Сэлэнгэ	Алтанбулаг	1.2	0.25	0.67	2.47	1.61
253	Сэлэнгэ	Баруунбүрэн	0.75	2.2	0.66	4.40	2.24

254	Сэлэнгэ	Баянгол	0.55	1.65	0.58	1.69	1.51
255	Сэлэнгэ	Бугант	0.7	1.3	0.59	4.38	2.02
256	Сэлэнгэ	Дулаанхаан	0.38	0.46	0.45	6.38	2.12
257	Сэлэнгэ	Ерөө	0.75	0.92	0.49	3.58	1.77
258	Сэлэнгэ	Жавхлант	0.5	0.72	0.68	6.05	2.21
259	Сэлэнгэ	Зүүнбүрэн	0.65	0.5	0.45	4.77	1.88
260	Сэлэнгэ	Номгон	0.9	1.6	0.59	5.96	2.46
261	Сэлэнгэ	Орхон	0.75	1.8	0.54	5.59	2.37
262	Сэлэнгэ	Орхонтуул	1.25	2.2	0.6	6.12	2.72
263	Сэлэнгэ	Рашаант	0.38	2	0.63	6.30	2.46
264	Сэлэнгэ	Сант	0.55	2.2	0.62	5.80	2.45
265	Сэлэнгэ	Түнхэл	0.25	2.65	0.64	3.63	2.02
266	Сэлэнгэ	Түшиг	1.1	1.3	0.54	6.22	2.50
267	Сэлэнгэ	Хушаат	0.85	1.1	0.48	5.89	2.30
268	Сэлэнгэ	Хүдэр	0.45	1.6	0.51	4.94	2.10
269	Сэлэнгэ	Хэрх	0.47	2.1	0.64	3.99	2.05
270	Сэлэнгэ	Цагааннуур	0.98	1	0.57	2.12	1.59
271	Сэлэнгэ	Шаамар	0.4	0.21	0.45	5.62	1.92
272	Сэлэнгэ	Сайхан	0.7	1.6	0.57	0.63	1.33
273	Сэлэнгэ	Эмнэх БЭМТ					1.00
274	Сэлэнгэ	Номт хан ӨЗМТ					1.00
275	Сэлэнгэ	Ачит амьдрүүлалч ӨЗМТ					1.00
276	Сэлэнгэ	Хараа манал					1.00
277	Сэлэнгэ	Үйлст эмнэхүй					1.00
278	Төв	Алтанбулаг	1.2	0.51	0.88	4.19	2.06
279	Төв	Аргалант	1.1	1.31	0.89	6.76	2.71
280	Төв	Архуст	0.3	1.13	0.84	14.20	3.91

281	Төв		Батсүмбэр	0.7	1.35	0.83	0.80	1.39
282	Төв		Баян	1.15	0.78	1.03	5.65	2.44
283	Төв		Баяндэлгэр	0.9	1.06	0.9	6.70	2.59
284	Төв		Баянжаргалан	1.1	1.41	0.99	6.63	2.73
285	Төв		Баян-Өнжүүл	0.93	1.31	0.88	5.70	2.44
286	Төв		Баянхангай	1.6	1.53	0.89	14.10	4.37
287	Төв		Баянцагаан	1.4	1.12	0.98	6.22	2.68
288	Төв		Баянцогт	1.2	1.38	0.9	6.49	2.70
289	Төв		Баянчандмань	0.44	1.11	0.9	3.04	1.73
290	Төв		Борнуур	1.2	1.44	0.74	2.31	1.83
291	Төв		Бүрэн	0.64	1.92	0.92	4.65	2.28
292	Төв		Дэлгэрхаан	1	2.46	1.12	6.40	2.91
293	Төв		Жаргалант	1.78	1.71	0.73	0.94	1.78
294	Төв		Заамар	1.4	2.26	0.84	1.55	1.93
295	Төв		Лүн	1.2	1.75	0.73	5.26	2.48
296	Төв		Мөнгөнморьт	1	1.94	1.03	5.75	2.65
297	Төв		Өндөрширээт	1.4	2.31	0.75	6.02	2.81
298	Төв		Сүмбэр	0.8	2.06	0.76	6.47	2.67
299	Төв		Сэргэлэн	2.36	0.14	0.83	6.02	2.69
300	Төв		Утгаалцайдам	1.06	1.99	0.84	5.13	2.49
301	Төв		Цээл	0.9	2.22	0.76	5.13	2.47
302	Төв		Эрдэнэ	2	0.83	1.13	3.40	2.29
303	Төв		Эрдэнэсант	1.6	2.61	0.98	2.75	2.35
304	Төв		Баруун Зуунмод БН ӨГМТ					1.00
305	Увс		Бөхмөрөн	0.9	1.8	0.89	5.59	2.52
306	Увс		Давст	0.85	1.47	0.62	6.69	2.57
307	Увс		Завхан	1.7	1.8	0.76	6.24	2.85

308	Увс		Зүүнговь	1.04	1.4	0.72	4.79	2.27
309	Увс		Зүүнхангай	1.25	3.5	1.3	5.45	3.05
310	Увс		Малчин	0.9	1.05	1.06	5.35	2.37
311	Увс		Наранбулаг	1.5	0.9	0.82	2.92	1.96
312	Увс		Өлгий	1.8	1.11	1.13	5.35	2.67
313	Увс		Сагил	1.45	0.67	0.82	5.31	2.38
314	Увс		Тариалан	1.53	0.34	0.67	3.30	1.89
315	Увс		Түргэн	1.5	0.37	0.88	5.92	2.47
316	Увс		Тэс	1.2	1.8	0.58	2.09	1.81
317	Увс		Ховд	2.2	1.86	0.86	5.24	2.84
318	Увс		Хяргас	1	1.65	0.99	5.20	2.47
319	Увс		Цагаанхайрхан	1.8	2.4	1.26	5.93	3.08
320	Увс		Баруунтуруун	0.95	1.88	0.89	4.90	2.41
321	Увс		Өмнөговь	1.15	1.8	0.89	2.54	1.98
322	Увс		Өндөрхангай	1.4	2.7	0.89	4.28	2.58
323	Увс		Бат уржихуй ӨЭМТ					1.00
324	Увс		Дун цагаан ӨЭМТ					1.00
325	Увс		Элбэг өгөөж ӨЭМТ					1.00
326	Увс		Мөнхбишрэлт ӨЭМТ					1.00
327	Ховд		Алтай	2.4	3	0.95	4.10	2.92
328	Ховд		Буянт	1.5	0.25	0.86	3.66	1.99
329	Ховд		Дарви	1.6	2.2	1.06	4.59	2.66
330	Ховд		Дөргөн	2	1	0.85	4.46	2.45
331	Ховд		Дуут	0.75	0.8	1.65	6.10	2.60
332	Ховд		Зэрэг	4.1	1.41	0.83	4.10	3.08
333	Ховд		Манхан	1.2	0.8	0.98	2.95	1.90
334	Ховд		Мөнххайрхан	1.15	1.56	1.51	5.73	2.76
335	Ховд		Мянгад	1.8	0.45	0.85	3.68	2.12

336	Ховд	Үенч	1.5	3.65	0.98	3.38	2.65
337	Ховд	Ховд	0.7	0.33	1.23	3.94	1.93
338	Ховд	Цэцэг	3	2.32	1.15	4.35	3.08
339	Ховд	Чандмань	1.6	1.6	1.2	4.48	2.56
340	Ховд	Эрдэнэбүрэн	1.88	0.62	0.92	5.37	2.54
341	Ховд	Мөст	1.68	1.85	1.07	4.36	2.57
342	Ховд	Баатархайрхан ӨЗМТ					1.00
343	Ховд	Буянт ӨЗМТ					1.00
344	Ховд	Бугат ӨЗМТ					1.00
345	Ховд	Рашаант ӨЗМТ					1.00
346	Ховд	Жаргалан ӨЗМТ					1.00
347	Ховд	Булган ӨЗМТ					1.00
348	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	1.1	0.63	1.13	4.15	2.12
349	Хөвсгөл	Арбулаг	1	0.71	1.36	3.18	1.99
350	Хөвсгөл	Баянзүрх	1.2	1.27	1.17	3.29	2.12
351	Хөвсгөл	Бүрэнтогтох	1.02	0.51	0.97	2.82	1.76
352	Хөвсгөл	Галт	0.96	1.67	1.29	1.83	1.87
353	Хөвсгөл	Жаргалант	1.05	1.77	1.28	1.81	1.92
354	Хөвсгөл	Рашаант	0.94	1.54	1	3.53	2.10
355	Хөвсгөл	Ренчинлхүмбэ	2.1	2.43	1.14	2.38	2.43
356	Хөвсгөл	Тариалан	1.75	1.6	1.09	1.23	1.92
357	Хөвсгөл	Тосонцэнгэл	1	0.64	0.93	2.81	1.77
358	Хөвсгөл	Төмөрбулаг	1.45	0.73	1.05	2.90	1.98
359	Хөвсгөл	Түнэл	1.4	0.46	1.1	2.93	1.93
360	Хөвсгөл	Ханх	1.55	3.41	1.19	4.82	2.97
361	Хөвсгөл	Цагаан-Үүр	1.07	1.73	1.18	5.02	2.52
362	Хөвсгөл	Цагааннуур	1.15	2.52	1.12	6.00	2.89

363	Хөвсгөл	Цэцэрлэг	1.25	2.09	1.26	2.58	2.19
364	Хөвсгөл	Чандмань-Өндөр	0.98	1.37	1.38	4.43	2.37
365	Хөвсгөл	Эрдэнэбулган	1.24	1.6	0.83	4.47	2.33
366	Хөвсгөл	Их-Уул	0.98	1.12	1.14	3.10	1.98
367	Хөвсгөл	Улаан-Уул	1.15	1.74	1.14	3.00	2.13
368	Хөвсгөл	Хатгал	1.1	1.01	1.14	3.76	2.13
369	Хөвсгөл	Цагаан-Уул	1.25	1.31	1.14	1.53	1.78
370	Хөвсгөл	Шинэ-Идэр	1.12	1.23	1.14	4.37	2.30
371	Хөвсгөл	Гурван гал ӨЗМТ					1.00
372	Хөвсгөл	Энэрэл ӨЗМТ					1.00
373	Хөвсгөл	Далайн элбэрэлт ӨЗМТ					1.00
374	Хөвсгөл	Энх-Үйлс ӨЗМТ					1.00
375	Хөвсгөл	Дэлгэрмөрөн ӨЗМТ					1.00
376	Хэнтий	Батноров	0.45	1.05	0.76	4.17	1.91
377	Хэнтий	Батширээт	0.55	1.96	0.81	5.44	2.39
378	Хэнтий	Баян-Адарга	0.75	1.56	0.74	5.31	2.32
379	Хэнтий	Баянменх	0.52	1	0.8	6.41	2.38
380	Хэнтий	Баян-Овоо	0.55	1.43	0.67	6.15	2.38
381	Хэнтий	Баянхутаг	0.6	0.27	0.75	5.33	2.03
382	Хэнтий	Галшар	0.65	1.4	0.85	5.70	2.37
383	Хэнтий	Гурванбаян	0.35	1.2	0.87	15.68	4.24
384	Хэнтий	Дадал	0.8	2.8	0.72	4.32	2.38
385	Хэнтий	Дархан	0.65	1.45	0.92	6.02	2.47
386	Хэнтий	Дэлгэрхаан	0.6	1.38	0.9	6.08	2.44
387	Хэнтий	Жаргалхаан	0.55	1	0.97	5.57	2.27
388	Хэнтий	Мөрөн	0.55	0.3	0.95	6.24	2.26
389	Хэнтий	Норовлин	0.8	2.06	0.74	4.95	2.36

390	Хэнтий	Өлзийт	0.35	0.51	0.95	15.24	4.04
391	Хэнтий	Өмнөдэлгэр	0.85	1.4	0.96	2.29	1.78
392	Хэнтий	Тахилгат	0.45	0.5	0.82	16.24	4.23
393	Хэнтий	Хэрлэн Баян-Улаан	0.45	1.61	0.86	17.14	4.64
394	Хэнтий	Цэнхэрмандал	0.55	1.45	1.03	5.93	2.45
395	Хэнтий	Биндөр	0.75	1.8	0.85	3.24	1.99
396	Хэнтий	Бэрх	0.45	0.75	0.85	5.44	2.13
397	Хэнтий	Оюуны шим ӨЭМТ					1.00
398	Хэнтий	Хэрлэн дом ӨЭМТ					1.00
399	Хэнтий	Ач манал ӨЭМТ					1.00
400	Хэнтий	Цэцүүлэн дом ӨЭМТ					1.00
401	Улаанбаатар	Гачуурт тосгон	0.95	0.17	1.02	0.56	1.24
402	Улаанбаатар	Жаргалант тосгон	0.62	0.67	0.84	0.70	1.21
403	Улаанбаатар	Туул тосгон	0.64	0.37	0.86	3.56	1.74
404	Улаанбаатар	Хонхор тосгон	0.5	0.22	0.95	0.12	1.00
405	Улаанбаатар	Багахангай ДЭМТ	1.15	0.78	1.03	5.65	2.44
406	Улаанбаатар	Багануур Энэрэлт Өлзий ӨЭМТ					1.00
407	Улаанбаатар	Багануур Энх-Өрх ӨЭМТ					1.00
408	Улаанбаатар	Багануур Биваангирьд ӨЭМТ					1.00
409	Улаанбаатар	Налайх Нарны эрч ӨЭМТ					1.00
410	Улаанбаатар	Налайх Амь Эрдэнэ МТ					1.00
411	Улаанбаатар	Налайх Ачлал ӨЭМТ					1.00
412	Улаанбаатар	Налайх Суврага ӨЭМТ					1.00

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 3 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар А/38

Улаанбаатар
хот

**ХАЙГУУЛ, УУЛЫН АЖЛЫН БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН, МЭДЭЭГ
ХҮРГҮҮЛЭХ, ИРҮҮЛЭХ ЗААВАР БАТЛАХ ТУХАЙ**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх, Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 48 дугаар зүйлийн 48.1.1, 48.1.2, 48.6.2, 48.6.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг хүргүүлэх, ирүүлэх зааврыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/121 дүгээр, 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/202 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Батлагдсан зааврыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг Ашигт малтмалын хайгуулын хэлтэс /Б.Золбообаяр/, Уул уурхайн хэлтэс /Т.Зууннаст/-т тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Мөнхтуяа/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.БАЯНБААТАР

*Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2026 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн
А/38 дугаар тушаалын хавсралт*

**ХАЙГУУЛ, УУЛЫН АЖЛЫН БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН, МЭДЭЭГ
ХҮРГҮҮЛЭХ, ИРҮҮЛЭХ ЗААВАР**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйл болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”-ын дагуу Хайгуулын, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, тайлан, мэдээг (цаашид “төлөвлөгөө, тайлан, мэдээ” гэх) Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх, ирүүлэхэд энэ зааврыг баримтална.

1.2. Төлөвлөгөө, тайлан, мэдээг <http://gmis.mppam.gov.mn/> цахим хаягтай Геологи, уул уурхайн мэдээллийн системээр (цаашид “систем” гэх) хүргүүлэх, ирүүлэх (цаашид “ирүүлэх” гэх) ажиллагааг хэрэгжүүлнэ.

ХОЁР. Төлөвлөгөө, тайлан, мэдээг ирүүлэх нөхцөл

2.1. Төлөвлөгөө, тайлан, мэдээг ирүүлэх хугацааг тоолохдоо Захиргааны ерөнхий хуулийн 33 дугаар зүйл, Иргэний хуулийн наймдугаар бүлгийг баримтална.

2.2. Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд (цаашид “хэрэглэгч” гэх)-ийн системд нэвтрэх эрх хүссэн албан бичгийг үндэслэн холбогдох нэгж нь Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэлтэй цахим шуудангийн хаяг болон гар утасны дугаарт ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

2.3. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд (цаашид “хэрэглэгч” гэх)-ийн албан бичгээр ирүүлсэн цахим шуудангийн хаяг болон гар утасны дугаарт ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

2.4. Хэрэглэгч нь төлөвлөгөө, тайлан, мэдээг системээр ирүүлэхдээ итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эрх барих этгээдийн тоон гарын үсгийг ашиглана.

2.5. Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эрх барих этгээд нь ирүүлж буй төлөвлөгөө, тайлан, мэдээний боловсруулалтад хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

2.6. Хэрэглэгч нь албажсан төлөвлөгөө, тайлан, мэдээнд өөрчлөлт оруулах тохиолдолд хүсэлтээ албан бичгээр ирүүлнэ.

2.6.1.Нэмэлт төлөвлөгөө – тэсэлгээ, ус, цахилгаан хангамж, байгаль орчин, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт болон эрэл, хайгуулын ажлын аргачлал, хайгуулын ажлын төлөвлөгөөний төсөл, төсвийн нэгтгэл зэрэгт өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох маягт, мэдээллийг шинэчлэн оруулна.

2.6.2.Тодотгол төлөвлөгөө – ашиглалтын нөөц, уулын цулын хэмжээнд, ашиглалт, баяжуулалтын үзүүлэлтэд өөрчлөлт орсон тохиолдолд тодотгол төлөвлөгөөг ирүүлнэ. Техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-д тодотгол орсон бол шаардлагатай тохиолдолд тодотгол төлөвлөгөөг ирүүлж болно. Тодотгол төлөвлөгөө нь өмнө албажсан төлөвлөгөөний бүх мэдээллийг агуулж болно.

2.7.Энэ заавартай хэрэглэгч сайтар танилцаж, төлөвлөгөө, тайлан, мэдээг батлагдсан маягт болон хавсралтад заасан шаардлагын дагуу бүрэн, үнэн зөв гаргаж ирүүлнэ. Маягтад дурдсан үзүүлэлтүүд болон эрэл хайгуулын ажил гүйцэтгэсэн аргачлал, бүлгийн бичвэр мэдээлэлтэй уялдаатай байна.

2.8.Хавсралт зургийг стандартын шаардлагад нийцүүлэн холбогдох бичвэр мэдээлэлтэй уялдаатай, ойлгомжтой хийж, PDF форматаар хавсаргана. Төлөвлөгөө, тайлангийн хавсралт зураг нь хайгуулын ажлын хувьд газарзүйн солбицлын систем (WGS84), уулын ажлын хувьд тэгш өнцөгт солбицлын систем (UTM)-д байх ба тод харагдахуйц нягтаршилтай, хавсралтад заасан масштабын дагуу ирүүлнэ. Шаардлагатай бол фото, бүдүүвч зураг, диаграмм болон бусад холбогдох материалыг хавсралтаар ирүүлж болно.

2.9.Ирүүлсэн төлөвлөгөө, тайлангийн холбогдох хэсэгтэй тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн (цаашид “мэргэжилтэн” гэх) танилцаж, “хүлээн авах”, “буцаах”, “танилцахаас татгалзах” гэсэн шийдвэрийн аль нэгийг гаргана.

2.10.Мэргэжилтэн хариуцсан хэсэгтэй танилцаж хүлээн авснаар дараагийн хэсэгт шилжих бөгөөд бүх хэсэгтэй бүрэн танилцаж дууссаны дараа нэгжийн дарга эцэслэн шийдвэрлэнэ.

2.11.Буцаах шийдвэр гаргасан тохиолдолд хэрэглэгч төлөвлөгөө, тайлан, мэдээнд засвар хийх боломжтой болно. Мэргэжилтэн энэ зааврын 5.5-д заасан танилцахаас татгалзах шийдвэр гаргасан тохиолдолд уг шийдвэрийг нэгжийн дарга эцэслэн шийдвэрлэнэ.

2.12.Хэрэглэгч нь системийн “явц харах” хэсгээс төлөвлөгөө, тайлантай танилцаж буй үйл явцыг хянах боломжтой бөгөөд системд бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар болон гар утасны дугаарт мессежээр тухай бүр мэдэгдэж болно.

2.13.Хэрэглэгч нь засварт буцсан төлөвлөгөө, тайлан, мэдээний холбогдох засварыг бүрэн хийж, ажлын 5 хоногийн дотор ирүүлнэ. Энэ

хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол тайлантай танилцахаас татгалзах үндэслэл болно.

2.14.Хэрэглэгч нь танилцахаас татгалзсан шийдвэрийн дагуу асуудал, зөрчлийг арилгасан тухай албан бичиг (шаардлагатай гэж үзсэн нотлох баримтыг хавсаргах) ирүүлснээр нэгжийн дарга төлөвлөгөө, тайлантай үргэлжлүүлэн танилцах эсэхийг шийдвэрлэнэ.

2.15.Хэрэглэгч нь Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан хуулийн хугацаанд төлөвлөгөө, тайлан, мэдээг ирүүлээгүй тохиолдолд холбогдох төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөрчлийн тэмдэглэл, шийтгэврийн хуудас эсхүл шаардлагатай бусад баримт бичгийг хавсарган албан бичиг ирүүлнэ.

ГУРАВ. Хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан

3.1.Хэрэглэгч хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг Хавсралт-1, Хавсралт-2-т заасан шаардлагын дагуу боловсруулан, системээр ирүүлнэ.

3.2.Байгаль орчны нөхөн сэргээлт хийсэн тухай мэдээг Хавсралт-2, Маягт 7-д заасны дагуу Байгаль орчны хяналтын алба, байгаль орчны хяналтын албагүй тохиолдолд Орон нутгийн байгаль орчны байцаагчийн тодорхойлолт ирүүлнэ.

3.3.Шүүхийн шийдвэрээр тусгай зөвшөөрлийн эрх сэргэсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг үргэлжлүүлэн тооцсон жилийн хугацаагаар авч үзнэ.

3.4.Системийн хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан нь хүлээн авах, геологи, зардлын доод хэмжээ, эцсийн шийдвэр гэсэн 4 хэсэгтэй байна.

ДӨРӨВ. Уулын ажлын болон Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан

4.1.Уулын ажлын болон Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг Хавсралт-3, Хавсралт-4, Хавсралт-5-д заасан шаардлагын дагуу боловсруулж ирүүлнэ.

4.2.Уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцах, хүлээн авах системийн үйл ажиллагаа нь нөөц, технологи, бүтээгдэхүүн борлуулалт, эдийн засаг, эцсийн шийдвэр гэсэн 5 хэсгээс бүрдэнэ.

4.3.Энэ зааврын Хавсралт-5-ын 2.2-т заасан Уулын ажлын дэвсгэр зургийг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж ирүүлнэ.

4.4.“Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 3.13 дугаар заалтыг үндэслэн үйлдвэрийг түүхий эдээр хангаж байгаа уурхайн уулын ажлын төлөвлөгөө, тайлан албажсны дараа ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөө, тайлантай танилцана.

ТАВ. Цахим хэлбэрээр ирүүлсэн төлөвлөгөө, тайлан, мэдээг албажуулах

5.1. Системд хүлээн авсан төлөвлөгөө, тайланг хэрэглэгч 2 хувь цаасан хэлбэрээр холбогдох нэгжид хэрэглэгчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтны гарын үсэг болон компанийн тамгаар албажуулан ирүүлнэ.

5.2. Цаасан хэлбэрийн төлөвлөгөө, тайлан нь дараах бүрдэл хэсэгтэй байна.

5.2.1. Төлөвлөгөө нь албажуулсан нүүр хуудас, QR код бүхий маягт, Хавсралт-1, Хавсралт-5-д заасан зураг;

5.2.2. Тайлан нь албажуулсан нүүр хуудас, QR код бүхий маягт;

5.3.5.2-т заасны дагуу ирүүлсэн төлөвлөгөө, тайланг холбогдох нэгж нь албажуулан нэг хувийг хэрэглэгчид, нөгөө хувийг байгууллагын архивд хадгална.

5.4. Цаасан болон системд албажсан төлөвлөгөө, тайланд зөрүү гарсан тохиолдолд систем дэх мэдээллийг баримтална.

5.5. Дараах тохиолдолд төлөвлөгөө, тайлан, мэдээг танилцахаас татгалзах үндэслэл болно:

5.5.1. ТЭЗҮ-гүй эсхүл нэмэлт тодотгол хийх нөхцөл үүссэн;

5.5.2. Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн ашигт малтмалын нөөцийг олборлож дууссан, бүртгэгдсэн нөөцгүй, нөөцийг нь тодорхойлох боломжгүй;

5.5.3. Эрх бүхий хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн төлөвлөгөө, тайланд хязгаарлалт хийх;

5.5.4. Өмнөх жилүүдийн тайланг албажуулаагүй тохиолдолд тухайн төлөвлөгөөтэй;

5.5.5. Өмнөх жилийн тайланг ирүүлээгүй бол дараа жилийн төлөвлөгөөтэй;

5.5.6. Өмнөх жилийн тайлан ирүүлээгүй тохиолдолд тухайн төлөвлөгөөтэй 2 дугаар сарын 15-ны өдрөөс хойш;

5.5.7. Өмнөх жилийн тайлан албажуулаагүй тохиолдолд тухайн төлөвлөгөөтэй 5 дугаар сарын 15-ны өдрөөс хойш;

5.5.8. Өмнөх жилүүдийн тайлан албажуулаагүй тохиолдолд тухайн жилийн тайлантай;

5.5.9. Өмнөх жилийн тайланг ирүүлээгүй бол тухайн жилийн тайлантай;

5.5.10. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өмнөх оны хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг дараа оны төлөвлөгөөг ирүүлэхээс өмнө холбогдох нэгжээр албажуулаагүй;

5.5.11. Уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний тухайн он дууссан тохиолдолд;

5.5.12.Засварт буцаасан төлөвлөгөө, тайлан, мэдээний алдааг засварлалгүй 3 удаа илгээсэн;

5.5.13.Хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээ нь хуульд заасан хэмжээнд хүрээгүй, баримтаар нотлогдоогүй;

5.5.14.Тодорхой шалтгаанаар хайгуулын ажил хийх нөхцөл бүрдэхгүй байх тохиолдолд тухайн оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хүсэлтээ ирүүлбэл тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөөг;

ЗУРГАА. Бусад

6.1.Системд хандах хүсэлт гаргасан төрийн байгууллагад Ашигт малтмал, газрын тосны даргын тушаалын дагуу системийн холбогдох хэсэгт хандах эрхийг олгож болно.

6.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу мэдээллийг ашиглах эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан, нууц задруулахгүй байх баталгааг бичгээр гаргасан байна.

6.3.Системийн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл үүссэн, сэжигтэй хандалт илэрсэн, гэрээнд зааснаас өөр зорилгоор мэдээллийг ашигласан болон эрх бүхий байгууллагаас шаардсан тохиолдолд тухайн системийг нэвтрэх эрхийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хаана.

*Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн
үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг
хүргүүлэх, ирүүлэх зааврын Хавсралт-1*

ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.Төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна.

1.1.Геологи хайгуулын ажлын төлөвлөгөөг 1 жилийн хугацаагаар боловсруулж, гүйцэтгэх ажлын төрөл, хэмжээ, зардлыг тооцсон байна.

1.2.Хавсралт зураг: Геологи хайгуулын ажлын төлөвлөгөөнд Геологийн болон ашигт малтмалын зураг, Төлөвлөлтийн зургуудыг хавсралт байдлаар үйлдэж оруулна. Зургийн ачааллаас (Зурагт тусгах мэдээллээс) хамааруулан эдгээр зургуудыг тусад нь болон нэгтгэсэн байдлаар зохиож болно. Зургийн масштабыг эрэл, хайгуулын ажил гүйцэтгэх талбайн хэмжээ, газрын гадаргын байдал, судалгааны ажлын үе шат, зорилгоос хамааруулан оновчтой байдлаар сонгосон байна. Зургийн өнгө, тэмдэглэгээ, таних тэмдгүүд болон холбогдох бусад зүйлүүд нь геологийн зурагт тавьдаг (тавигдах ерөнхий) шаардлагыг хангасан байна. Мөн төлөвлөгөөний зохих (тухайн) бүлгүүдэд шаардлагатай бол бүдүүвч, зургуудыг оруулж болно.

1.3.Хурдас чулуулгийн (бичиглэлийг Монголын литостратиграфийн кодексын дагуу бичих) стратиграфийн ангиллын бичлэгийг Монголын литостратиграфийн кодексын дагуу хийсэн байна.

1.4.Төлөвлөгөөнд (байгаль орчныг хамгаалах зардлыг 1 маягтад болон түүнтэй уялдсан байдлаар текст хэлбэрээр бичин ирүүлэх) байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд зарцуулагдах зардлыг тооцсон байна.

1.5.Хайгуулын ажлын төлөвлөгөөг боловсруулсан геологийн болон санхүүгийн холбогдох ажилтнууд нь гарын үсгээ зурж, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн удирдлага нь огноотойгоор баталгаажуулсан байна.

2.Төлөвлөгөө дараах хэсгүүдээс бүрдэнэ.

2.1.Ерөнхий бүлэг

2.2.Геологийн тогтоц ба ашигт малтмал

2.3.Эрэл хайгуулын ажлын арга аргачлал

2.4.Геологи, ашигт малтмал, төлөвлөлтийн зураг

2.5.Хайгуулын ажлын төлөвлөгөөний төсөл, төсвийн нэгтгэл

*Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн
үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ
хүргүүлэх, ирүүлэх зааврын Хавсралт-2*

ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Тайлан дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.
 - 1.1. Бичвэр мэдээлэл;
 - 1.1.1. Оршил
 - 1.1.2. Геологийн тогтоц
 - 1.1.3. Эрэл, хайгуулын ажлын аргачлал
 - 1.1.4. Эрэл, хайгуулын ажлын үр дүн
 - 1.1.5. Байгаль орчны нөхөн сэргээлт
 - 1.1.6. Дүгнэлт
 - 1.2. Холбогдох стандарт шаардлага хангасан хавсралт зураг;
 - 1.2.1. Геологи-ашигт малтмалын зураг
 - 1.2.2. Баримт материалын зураг
 - 1.2.3. Геохими, Шлих, Геофизикийн судалгааны баримтжилт болон үр дүнгийн зургууд
 - 1.2.4. Геологийн болон геофизикийн зүсэлтүүд, цооногийн болон уулын ажил (суваг, шурф, траншей г.м.)
 - 1.3. Маягт
 - 1.3.1. Гүйцэтгэсэн геологи хайгуулын ажил, Маягт 1
 - 1.3.2. Гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын зардлын задаргаа, Маягт 2
 - 1.3.3. Өрөмдлөгийн болон уулын ажлын мэдээлэл, Маягт 3
 - 1.3.4. Дээж, сорьцын лабораторийн шинжилгээний мэдээлэл, Маягт 4
 - 1.3.5. Талбайд тогтоосон ашигт малтмалын мэдээлэл, Маягт 5
 - 1.3.6. Бүрдүүлсэн анхдагч материалын жагсаалт, Маягт 6
 - 1.3.7. Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэдээ, Маягт 7
 - 1.3.8. Ажиллах хүчний мэдээ, Маягт 8
 - 1.3.9. Хөрөнгө оруулалтын мэдээ, Маягт 9
 - 1.3.10. Хайгуулын ажлын зардлын дүнгийн задаргаа, Маягт 10
 - 1.3.3. Өрөмдлөгийн болон уулын ажлын мэдээлэл, Маягт 3
 - 1.3.4. Дээж, сорьцын лабораторийн шинжилгээний мэдээлэл, Маягт 4
 - 1.3.5. Талбайд тогтоосон ашигт малтмалын мэдээлэл, Маягт 5
 - 1.3.6. Бүрдүүлсэн анхдагч материалын жагсаалт, Маягт 6
 - 1.3.7. Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэдээ, Маягт 7
 - 1.3.8. Ажиллах хүчний мэдээ, Маягт 8
 - 1.3.9. Хөрөнгө оруулалтын мэдээ, Маягт 9
 - 1.3.10. Хайгуулын ажлын зардлын дүнгийн задаргаа, Маягт 10
 - 1.4. Хайгуулын ажлын жилийн тайланг хянуулж, хүлээлгэж өгөх үед шаардлагатай анхдагч материал, санхүүгийн баримт, гэрээгээр гүйцэтгүүлсэн геологи, геофизик, геохими, гидрогеологи, өрөмдлөг, уулын ажил, топогеодези, лаборатори гэх мэт ажлуудын үр дүн, тэдгээрийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн албан ёсны баримт бичиг (гэрээ, гэрээ дүгнэсэн акт, лабораторийн захиалгын хуудас, шинжилгээний үр дүн)-ийг саадгүйгээр ирүүлж хянуулна. Холбогдох

мэдээ, мэдээлэл нь цаасан болон тоон хэлбэрээр бичигдсэн байж болно.

*Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн
үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг
хүргүүлэх, ирүүлэх зааврын Хавсралт-3*

**УУЛЫН АЖЛЫН БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 1.Төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 1.1.Эрдэс, баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хүлээн авч системд бүртгүүлсэн ашигт малтмалын ордыг ашиглах ТЭЗҮ, зураг төслийг баримтлах (маягтан мэдээлэл, хавсралт зураг болон бусад материал);
 - 1.2.Албажсан уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайланд үндэслэх;
 - 1.3.Тухайн жилийн төлөвлөгөөг өмнөх оны эцсийн байдлаарх бодит буюу маркшейдрийн хэмжилтийн дэвсгэр зурагт үндэслэх;
 - 1.4.Тухайн ордыг ашиглаж дуусах сүүлийн жилийн төлөвлөгөөтэй өмнөх жилийн тайлан ирүүлээд албажуулсны дараа танилцана.
 - 1.5.Ашигт малтмалын нөөцийг бэлтгэх, түүнийг зүй зохистой иж бүрэн олборлох, ашиглалтын хаягдал, бохирдлыг багасгах;
 - 1.6.ТЭЗҮ-ийн мэдээлэл, бусад холбогдох баримт бичиг, материалыг системд оруулсан байх;
 - 1.7.Ашиглалтын систем, технологийн дагуу уурхайн тухайн оны бэлтгэл болон үндсэн малталт, хөрс хуулалт, олборлолтын оновчтой хэмжээг тооцон түүнийг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, материалыг тодорхойлох;
 - 1.8.Ашигт малтмалыг баяжуулалт, боловсруулалтын технологийн дагуу хаягдал багатайгаар стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
 - 1.9.Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх;
 - 1.10.Холбогдох бусад дүрэм, журам, заавар, стандартад нийцүүлэн боловсруулна.
- 2.Төлөвлөгөө нь хоёр төрөл байна.
 - 2.1.Уулын ажлын болон Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө;
 - 2.2.Үйл ажиллагаа явуулахгүй тухай Х төлөвлөгөө;
 - 3.2.1.-д заасан төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.
 - 3.1.Бичвэр мэдээлэл;
 - 3.1.1.Ерөнхий бүлэг;
 - 3.1.2.Нөөц;
 - 3.1.3.Ашиглалтын техник, технологи;

- 3.1.4.Баяжуулалтын техник, технологи;
- 3.1.5.Дэд бүтэц;
- 3.1.6.Байгаль орчин;
- 3.1.7.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй;
- 3.1.8.Эдийн засаг, татвар хураамж;

3.2.Уул уурхайн график зураг;

3.2.1.Энэ зааврын Хавсралт-5-д заасан шаардлага хангасан байна.

3.3.Ашигт малтмалын тухай хуулийн 48.11 дэх хэсэгт заасны дагуу Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан маягт;

3.4.Хавсралт материал;

3.4.1.Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын лавлагаа;

3.4.2.Зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөрчлийн тэмдэглэл, шийтгэврийн хуудас;

3.4.3.Үйлдвэрийг хүдрийн (элс) түүхий эдээр хангах аж ахуйн нэгж хооронд байгуулсан гэрээ;

3.5.Төлөвлөгөөний бичвэр мэдээлэлд тухайн онд уурхай, үйлдвэр, цехэд ямар ажил үйлчилгээ хийх, тэдгээрийг төлөвлөх, төсөв, санхүүжилт, ажлын график гэх мэт төлөвлөлтүүдийг оруулна. Жич: Холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу ямар ажил үйлчилгээ явуулах талаараа төлөвлөнө.

4.2.2-д заасан Х төлөвлөгөө нь шалтгаан, нөхцөл байдлыг дурдсан мэдэгдэл байна.

*Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн
үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг
хүргүүлэх, ирүүлэх зааврын Хавсралт-4*

**УУЛЫН АЖЛЫН БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

1. Тайлан нь хоёр төрөл байна.
 - 1.1. Уулын ажлын болон Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайлан;
 - 1.2. Үйл ажиллагаа явуулаагүй тухай Х тайлан;
 2. Маркшейдерийн хэмжилтийн үр дүнд тулгуурлан тайланг боловсруулж, холбогдох бичиг баримт, материалын хамт ирүүлнэ.
 3. Ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэр нь тайлант оны эцэст түүхий эдийн овоолготой байвал маркшейдерийн хэмжилтийн тайлантай байна.
 4. Ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөнийг хийхдээ Эрдэс, баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хүлээн авч системд бүртгүүлсэн Хайгуулын ажлын үр дүнгийн тайланд үндэслэнэ. (маягтан мэдээлэл, хавсралт зураг болон бусад материал);
 5. Тайлан дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.
 - 5.1. Бичвэр мэдээлэл;
 - 5.1.1. Ерөнхий бүлэг;
 - 5.1.2. Нөөц;
 - 5.1.3. Ашиглалтын техник, технологи;
 - 5.1.4. Баяжуулалтын техник, технологи болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээлэл;
 - 5.1.5. Дэд бүтэц;
 - 5.1.6. Байгаль орчин;
 - 5.1.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй;
 - 5.1.8. Эдийн засаг, татвар хураамж;
 - 5.2. Уул уурхайн график зураг;
 - 5.2.1. Хавсралт-5-д заасан шаардлагыг хангаж ирүүлнэ.
 - 5.3. Ашигт малтмалын тухай хуулийн 48.11 дэх хэсэгт заасны дагуу Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан маягт;
 - 5.4. Хавсралт материал;
 - 5.4.1. Маркшейдерийн хэмжилтийн тайлан;
 - 5.4.2. Блок нээсэн, хаасан тухай акт;
 - 5.4.3. Үнэт металл олборлолтын жилийн тайлан;
 - 5.4.4. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан

орон нутагтай хамтран ажиллах гэрээг дүгнэсэн акт;

5.4.5. Аж ахуйн нэгж хооронд хийсэн гэрээ, гэрээ дүгнэсэн акт;
(он дамнасан гэрээтэй бол актыг он болгон дээр дүгнэж ирүүлэх)

5.4.6. Баяжуулах үйлдвэрийн технологийн хөндлөнгийн хяналт,
сорьцлолт хийлгэсэн тайлан;

5.4.7. Шаардлагатай бол дотоод борлуулалтын гэрээ, гэрээ
дүгнэсэн акт;

6. Х тайлан нь дараах бичиг баримтын бүрдэлтэй байна.

6.1. Үйл ажиллагаа явуулаагүй тухай болон түүний шалтгааныг
дурдсан мэдэгдэл;

6.2. Ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүйг нотолсон сум,
дүүргийн Засаг даргын тодорхойлолт;

6.3. Шаардлагатай бол үйл ажиллагаа явуулаагүй шалтгааныг
нотолсон баримт;

*Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн
үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг
хүргүүлэх, ирүүлэх зааврын Хавсралт-5*

**УУЛЫН АЖЛЫН БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАНГИЙН УУЛ УУРХАЙН
ГРАФИК ЗУРАГ, БАРИМТЫН ШААРДЛАГА**

1.Төлөвлөгөө, тайлангийн уул уурхайн график зураг, баримтыг Уул уурхайн график зураг, бичиг баримтын стандарт (MNS 6302-1:2011, MNS 63022:2011, MNS 6302-3:2011, MNS 6302-4:2011, MNS 6302-5:2011, MNS 6302-6:2011, MNS 6302-7:2011, MNS 6302-8:2011)-ын дагуу боловсруулж, системд PDF форматаар хавсаргана.

2.Төлөвлөгөө, тайланд дараах төрлийн зургийг хавсаргана.

2.1.Уурхай, үйлдвэрийн ерөнхий дэвсгэр зураг;

Тусгай зөвшөөрлийн хил бүрэн орсон, уурхай, үйлдвэр, тосгон гэх мэт дэд бүтцийн барилга, байгууламж бүгд багтсан.

“Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000 MNS 6702:2017” стандартын дагуу

2.2.Уулын ажлын дэвсгэр зураг;

Уулын ажлын өрнөлийг бүрэн харуулсан, карьер, овоолго багтсан тухайн жилийн олборлолтын календарьчилсан зураг байна. Жич: Эрх зүйн зохицуулалтад хамрагдсан бол хил заагийг оруулсан байх.

Масштаб: 1:1000, 1:2000, 1:5000 (тохирох масштабаар)

2.3.Хөндлөн ба дагуу зүсэлт;

Масштаб: 1:1000, 1:2000, 1:3000 (тохирох масштабаар)

2.4.Олборлолтод өртсөн давхаргын нөөцийн дэвсгэр зураг;

Масштаб: 1:1000, 1:2000, 1:5000 (тохирох масштабаар)

2.5.Тухайн жилд олборлосон блок, хэсэглэлийг нээсэн, хаасан дэвсгэр болон зүсэлт зураг

2.6.Тэсэлгээний ажлын паспорт;

Тоног төхөөрөмжийн ухаж, ачих ажлын паспорт; (тохирох масштабаар)

2.7.Баяжуулах үйлдвэрийн технологийн схем;

Тухайн жилийн тоо чанар, ус булингын тооцоотой схем зураг байх ба А4-ийн хэмжээнээс том зургийг хавсралтаар оруулна.

2.8.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх ажлын зураг;

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх ажлын хэмжээ, тооцоо, авах арга хэмжээний төлөвлөгөө, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн технологи, нөхөн сэргээлтийн талбайн дэвсгэр зураг

Масштаб: 1:1000, 1:2000

ХОВД АЙМАГ МЯНГАД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 7/04

Баянхошуу

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 7 дугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Мянгад сумын нутаг дэвсгэрт мөрдөгдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлбөр, хураамжийн хэмжээний дагуу иргэн, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад ногдуулалт хийж, орлогыг хураан сумын татварын орлогод төвлөрүүлж байхыг сумын Засаг дарга /Б.Батхишиг/, Татварын Улсын байцаагч /Д.Асенгүл/ нарт үүрэг болгосугай

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 25-ны 5/4 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ИДЭРЗАЯА

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 7/04 дүгээр тогтоолын хавсралт

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

Д/Д	Хураамж төлөх субъект	Хэмжих нэгж	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
1	Засаг даргын Тамгын газар	Сар/төг	10,000
2	Ерөнхий боловсролын сургууль	Сар/төг	11,700
3	Хүүхдийн цэцэрлэг	Сар/төг	7,500
4	Эрүүл мэндийн төв	Сар/төг	12,500
5	Соёлын төв	Сар/төг	5,800
6	Цагдаагийн тасаг	Сар/төг	4,160
7	Эмийн сан	Сар/төг	1,700
8	Банк санхүүгийн байгууллага	Сар/төг	3,400
9	Халуун усны газар	Сар/төг	4,150
10	Худалдаа үйлчилгээ эрхлэгч	Сар/төг	10,000
11	Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага	Сар/төг	20,900
12	Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага	Сар/төг	100,000
13	Эрчим хүчний дэд станц	Сар/төг	4,150
14	Шатахуун түгээх станц	Сар/төг	10,000
15	Дулааны цахилгаан станц	Сар/төг	37,500
16	Хүдэр цагаалах талбай	Сар/төг	29,150
17	Айл өрх	Сар/төг	500

Тайлбар: Нэг өрхийг дунджаар 3 гишүүнтэй гэж тооцон сард 1 гишүүнээс 170 төгрөгийн хураамж авахаар тооцсон болно.

ӨМНӨГОВЬ АЙМАГ НОЁН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 6/12

Ноён сум

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөгдөх малын тоо толгойд оногдуулах албан татварын жилд ногдуулах хэмжээг тэг төгрөгөөр баталсугай.

2.Уг тогтоолын хэрэгжилтийг ханган Хууль зүй, дотоод хэргийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 06 сарын 25-ны өдрийн 3/01 тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

М.ЦОГОО

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 2 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 9/07

Баянбулаг

**“БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ”-Д
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14, 35.1.18, 48 дугаар зүйлийн 48.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 18-ны 11/03 тоот тогтоолоор батлагдсан журмын 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын IX хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны нэмэлт өөрчлөлт, Газрын тухай хуулийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны нэмэлт өөрчлөлт, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 11/03 тоот тогтоолоор батлагдсан “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-д дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсугай.

Энэ журмын 2.6-д заасан Сумын Засаг дарга бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндэслэн бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу болзол, гэрээгээр малчдад хэсэг, бүлэг (цаашид “БАХ” гэх)-ээр ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулна гэсэн заалтыг “Сумын Засаг дарга бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндэслэн бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу болзол, гэрээгээр малчдад хэсэг, бүлэг (цаашид “Малчин өрхийн анхдагч холбоо” гэх)-ээр ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулна” гэж өөрчлөх.

Энэ журмын 4.1-д заасан Сумын Мал эмнэлэг, үржлийн тасаг дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэсэн заалтыг “Сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн тасаг, Газрын даамал, Мал эмнэлэгийн тасаг багийн Иргэдийн Нийтийн хурал дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх.

Энэ журмын 4.1.1-д заасан БАХ-ын гишүүн-малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, бэлчээрийг зөв ашиглах мэдлэг олгох, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулах; гэсэн заалтыг “Малчин өрхийн анхдагч холбооны гишүүн-малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, бэлчээрийг зөв ашиглах мэдлэг олгох, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулах” гэж өөрчлөх.

Энэ журмын 4.5.2-д заасан сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндэслэн Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасны дагуу БАХ-т бэлчээрийг болзол, гэрээгээр ашиглуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага, үр дүнг тооцож ажиллах; гэсэн заалтыг “Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндэслэн Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасны дагуу Малчин өрхийн анхдагч холбоо бэлчээрийг болзол, гэрээгээр ашиглуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага, үр дүнг тооцож ажиллах” гэж өөрчлөх.

Энэ журмын 4.5.4-д заасан энэ журмыг мөрдөн ажиллаж байгаа баг, малчин өрх, БАХ-д давуу эрхтэйгээр хөрөнгө санхүү, бодлогын дэмжлэг үзүүлэх; гэсэн заалтыг “Энэ журмыг мөрдөн ажиллаж байгаа баг, малчин өрх, Малчин өрхийн анхдагч холбоо давуу эрхтэйгээр хөрөнгө санхүү, бодлогын дэмжлэг үзүүлэх” гэж өөрчлөх.

Энэ журмын 4.5.5-д заасан гэрээнд заасны дагуу малын тоог бэлчээрийн даацад тохируулах нөхцөлийг удаа дараа хангаж байгаа БАХ-ыг Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-д заасан байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгодог “Ногоон гэрчилгээ” олгуулахаар холбогдох байгууллагад уламжлах; гэсэн заалтыг “Гэрээнд заасны дагуу малын тоог бэлчээрийн даацад тохируулах нөхцөлийг удаа дараа хангаж байгаа Малчин өрхийн анхдагч холбоог Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-д заасан байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгодог “Ногоон гэрчилгээ” олгуулахаар холбогдох байгууллагад уламжлах” гэж өөрчлөх.

Энэ журмын 4.6.2-д заасан энэ журам, тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, БАХ-тай байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хянах; гэсэн заалтыг “Энэ журам, тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, Малчин өрхийн анхдагч холбоотой

байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хянах” гэж өөрчлөх.

Энэ журмын 5.1-д заасан Иргэний хуулийн 481.1-т заасан бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл буюу БАХ-ийн зохион байгуулалтад орсон малчдад сумын Засаг дарга бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу болзол, гэрээ (цаашид “бэлчээр ашиглалтын гэрээ” гэх)-гээр ашиглуулна гэсэн заалтыг “Иргэний хуулийн 48.1.1-т заасан бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл буюу Малчин өрхийн анхдагч холбооны зохион байгуулалтад орсон малчдад сумын Засаг дарга бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу болзол, гэрээ (цаашид “бэлчээр ашиглалтын гэрээ” гэх)-гээр ашиглуулна” гэж өөрчлөх.

Энэ журмын 5.2-д заасан БАХ, түүний гишүүн малчин дараахь эрхийг эдэлнэ гэсэн заалтыг “Малчин өрхийн анхдагч холбоо, түүний гишүүн малчин, мал бүхий өрх дараахь эрхийг эдэлнэ” гэж өөрчлөх.

Энэ журмын 5.2.2.1-д заасан тухайн баг, сумын нутаг дэвсгэрийн 50-аас доошгүй хувь нь гантай байсан нь тогтоогдсон нөхцөлд нийт малчин өрхийг бэлчээр ашиглалтын татвараас чөлөөлнө гэсэн заалтыг “Тухайн баг, сумын нутаг дэвсгэрийн 50-аас доошгүй хувь нь гантай байсан нь тогтоогдсон нөхцөлд нийт малчин өрхийн малын тоо толгойн албан татварыг 0 төгрөгөөр тогтооно” гэж өөрчлөх.

Энэ журмын 5.2.3-д заасан Дор дурдсан тохиолдолд малчин өрх, түүний мал бэлчээр ашиглалтын гэрээнд заасан малын тоог бэлчээрийн даацад тохируулах зохицуулалтад хамрагдахгүй байх гэсэн заалтыг “Дор дурдсан тохиолдолд малчин болон мал бүхий өрх нь бэлчээр ашиглалтын гэрээнд заасан малын тоог бэлчээрийн даацад тохируулах зохицуулалтад хамрагдахгүй байх” гэж өөрчлөх.

Энэ журмын 5.3-д заасан БАХ, түүний гишүүн малчин бэлчээр ашиглахтай холбогдсон дараахь үүргийг хүлээнэ гэсэн заалтыг “Малчин өрхийн анхдагч холбоо, түүний гишүүн малчин, мал бүхий өрх бэлчээр ашиглахтай холбогдсон дараахь үүргийг хүлээнэ” гэж өөрчлөх.

Энэ журмын 5.3.1-д заасан бэлчээрийг өнжөөж, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гаргасан Засаг даргын шийдвэрийг дагаж биелүүлэх гэсэн заалтыг “Сумын Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 22 – ны өдрийн Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зун, намрын улиралд чөлөөлөх тухай А/54 тоот захирамжийг дагаж мөрдөнө” гэж өөрчлөх.

Энэ журмын 5.3.3-д заасан бэлчээр ашиглалтын гэрээгээр тохирсны дагуу энэ журмын 1.2-т заасан зардлыг тухайн оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор төлж барагдуулах гэсэн заалтыг “Гичгэнэ 01 дүгээр багийн нутаг Эрээлэнгийн тал, Жаргалант 04 дүгээр багийн нутаг Эрээн дэрс, Сүүл толгойн тал, Айдрын тал, Зээгийн тал зэрэг

газруудад шинээр хашаа, хороо барихыг хориглоно. Тус газруудад баригдсан зөвшөөрөлгүй хашаа, хороонуудыг буулгаж газар чөлөөлнө” гэж өөрчлөх.

Журмаас дараах заалтуудыг хасах:

4.5.7.Сумын бэлчээрийн даац хүрэлцээтэй жил өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжиж, хаваржих малыг оруулахдаа малчин өрхтэй байгуулсан гэрээгээр тохирсон төлбөрийг Бэлчээрийн санд оруулсны дараагаар бэлчээр нутгийг зааж өгөн нэвтрүүлэх;

4.5.8.Өмнөх жилийн гэрээний үүргээ биелүүлсний дараа буюу энэ журмын 1.2-т заасан зардлыг Бэлчээрийн санд төвлөрүүлснийг үндэслэн бэлчээр ашиглалтын гэрээг сунгах.

4.6.3.Бэлчээр ашиглалтын гэрээнд заасны дагуу энэ журмын 1.2-т заасан зардлыг хурааж, энэ журмын 6.1-д заасан Бэлчээрийн сан (цаашид “Бэлчээрийн сан” гэх)-д төвлөрүүлэх;

4.6.4.Тухайн жилд Бэлчээрийн санд хуримтлагдсан хөрөнгөөр санхүүжүүлэхээр багийн иргэдийн Нийтийн Хурлаас шийдвэрлэсэн ажлыг хэрэгжүүлэх.

5.2.2.Бэлчээрийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал гаргах, уг арга хэмжээний явц, гүйцэтгэлд болон сангийн зарцуулалтын байдалд хяналт тавих;

5.2.2.2.Хонин толгойд шилжүүлснээр малчин өрхийн 1 гишүүнд ногдох 100 хүртлэх толгой малыг татвараас чөлөөлнө;

5.2.2.3.Энэ журмын 1.2-т заасан зардлын хэмжээ хонин толгой тутамд 500 төгрөгөөс, 6.3.4-т заасан төлбөрийн хэмжээ хонин толгой тутамд хоногт 10 төгрөгөөс хэтрэхгүй байна.

Зургаа. Бэлчээрийн сан

6.1.Бэлчээрийн сангийн хөрөнгийг тухайн багийн Засаг даргын дэргэдэх Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 28.8-т заасан мөнгөн хөрөнгийн санд төвлөрүүлнэ.

6.2.Багийн бэлчээрийн санг сумын бэлчээр ашиглагчдын холбоонд баг бүрийн тусгай тохиргоотой шилэн данс хэлбэрээр байршуулж болно.

6.3.Бэлчээрийн сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

6.3.1.Энэ журмын 1.2-т заасан зардал;

6.3.2.Мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслийн хөрөнгө;

6.3.3.Бэлчээрийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас хуваарилсан тухайн багаас хуримтлагдсан хөрөнгийн хэмжээтэй тэнцэх хэмжээний хөрөнгө;

6.3.4.Энэ журмын 4.5.2-д заасны дагуу өөр аймаг, сумын

нутгаас оруулсан малын хонин толгой тутамд гэрээгээр тохирсон мөнгөн төлбөр;

6.3.5.Хандив, тусламж, бусад эх үүсвэр.

6.4.Бэлчээрийн сангийн хөрөнгийг дараахь үйл ажиллагаанд зарцуулна:

6.4.1.Доройтсон, хэт доройтсон бэлчээрийг нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаа (бусад малчдыг эрх ашгийг хөндөхгүйгээр);

6.4.2.Ашиглагдахгүй бэлчээрийг ашиглах зорилгоор хөв, цөөрөм, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх;

6.4.3.Багийн хэмжээнд ашиглах хадлан тэжээлийн талбай бий болгох;

6.4.4.Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх;

6.4.5.Бэлчээрт үүлэнд зориудаар нөлөөлөх зорилгоор генератор суурилуулах, түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд /түлш авах, үүлэнд зориудаар нөлөөлөх/;

6.4.6.Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий нийтээр ашиглах бэлчээрт мод, бут, сөөг тариалах,

6.5.Өөр аймаг сумд отроор яваа малчин өрхөд шаардлагатай бол сангаас дэмжлэг үзүүлж болно.

“Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-д дараах заалтуудыг шинээр нэмэх

1.4.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хуулинд өөрчлөлт орсон, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль шинээр батлагдаж 2024 оны 07 дугаар сарын 01 -ээс эхэлж хэрэгжиж эхэлсэн.

1.5.Малчид, мал бүхий иргэд нь өвөлжөө, хаваржааг дур мэдэн өндөр үнээр худалдах, худалдан авах явдал хэвийн үзэгдэл болж байгаа төдийгүй зуслан, намаржааг ч худалдаж, худалдан авч байна. Мөн бэлчээрийн нутгуудад дур мэдэн хашаа хороо барих, бусдад ашиг олох зорилгоор худалддаг зэрэг нь бод малын бэлчээрийг болон сумын нөөц бэлчээрийг үгүй хийх эрсдэл үүсгээд байна. Зуслан намаржааны нутагт өвөлжөө, хаваржааны зориулалтаар дур мэдэн хашаа хороо барьж, малчдыг зуслан намаржаанд нутаглуулахгүй гэхээс үүдсэн зөрчил маргаан гарсаар байна. Эдгээрийг үндэслэн Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, багийн иргэдийн Нийтийн Хурал иргэдийнхээ нийтлэг ашиг сонирхол, санал хүсэлтэд тулгуурлан оновчтой шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

1.6.Сумын бэлчээрийн даац хэтэрч, тодорхой бүс нутгийн бэлчээрт, бэлчээрийн доройтол бий болох зэрэг шалтгааны улмаас

энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн болно.

5.3.14.Багийн иргэдийн Нийтийн Хурлаас гарсан зуслан, намаржааны нутагт өвөлжөө, хаваржаа эзэмшүүлэхгүй. Зуслан намаржааны нутагт өвөлжөө, хаваржаа гаргасан бол газрыг чөлөөлүүлнэ.

5.3.15.Тухайн багийн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын болон нөөц бэлчээрийг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж тогтоож мөрдөнө.

5.3.16.Бэлчээр ашиглалтын гэрээнд заасны дагуу бэлчээрийн даацад тохирсон малыг өсгөн үржүүлэх;

5.3.17.Өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшүүлэхдээ малчин буюу мал бүхий өрхөд өвөлжөөний зориулалтаар 1, хаваржааны зориулалтаар 1 газар эзэмшүүлнэ.

5.3.18.Өвөлжөө, хаваржааг бусдад зарж худалдаалахдаа эзэмшүүлэгч тал буюу сумын Засаг даргатай заавал зөвшилцөнө.

2.Журмын хэрэгжилтийг ханган, үр дүнтэй ажиллахыг сумын Засаг дарга Н.Гансүхэд үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргад даалгасугай.

ДАРГА

Т.ГАНБАТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 3 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар А/88

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2001 оны “Дархлаажуулалтын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 34 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

2. Тушаал хүчингүй болсонтой холбогдуулан “Нөхөн дархлаажуулалт хийх журам”, “Тархвар судлалын заалтаар сэргийлэх тарилга хийх хугацаа, журам”, “Сэргийлэх тарилга, тарилгын дараах хүндрэл, тарилгаас татгалзсан тухай баримтыг бүртгэх журам”, “Сэргийлэх тарилга хийхэд харшлах өвчин, эмгэгийн жагсаалт”, “Тарилгын дараах хүндрэлийн жагсаалт”-ыг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор шинэчлэн боловсруулж, батлуулан Захиргааны хэм, хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан), Халдварт өвчин судлалын үндэсний төв (С.Энхболд)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын гурван өдөрт багтаан хүргүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатад даалгасугай.

САЙД

Ж.ЧИНБҮРЭН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 3 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/125

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2010 оны “Цусны аюулгүй байдлыг хангах талаарх заавар, журмыг шинэчлэн батлах тухай” 377 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын гурван өдөрт багтаан хүргүүлэхийг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатад даалгасугай.

САЙД

Ж.ЧИНБҮРЭН